



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2018 • IV • № 18

Б.ГАНБАТ
ИРГЭДИЙН
ГОМДОЛ,
МАРГААНЫГ
ЭРХ ЗҮЙН
ХЭМЖЭЭНИЙ
ХҮРЭЭНД
ЗОХИЦУУЛАХ
БОЛОМЖ
БҮРДЭНЭ

М.ЭНХБОЛД
МОНГОЛ
УЛСЫН
ЗЭЭЛЖИХ
ЗЭРЭГЛЭЛ
СҮҮЛИЙН
ЖИЛҮҮДЭД
САЙЖИРСАН

ЧАНАРГҮЙ
ЗЭЭЛИЙН
ХЭМЖЭЭ
2.7 %-ИАР
БУУРАВ

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЧНЫГ
БҮРДҮҮЛЭХИЙН
ТУЛД ...

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ЭРДЭНЭСИЙН САНГААС: ХХ ЗУУНЫ ДУНД ҮЕИЙН МӨНГӨН АЯГА

“ЦАХИМ БАНКНЫ АЮУЛГҮЙ БА ОЛОН УЛСЫН АНХДУГААР ФО



Монголбанк, Монголын Банкуудын холбоо, ХААН банк хамтран Монголбанкнаас санаачлан хэрэгжүүлж буй Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аяны хүрээнд “Цахим банкны аюулгүй байдал ба төлбөрийн эрсдэл анхдугаар форум”-ыг 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдлаа. Форумын үеэр “Цахим банкны аюулгүй байдал”, “Төлбөрийн картын эрсдэл”, “Цахим банк болон төлбөрийн аюулгүй байдлын тухай иргэд, олон нийтийн мэдлэг боловсрол” гэсэн үндсэн гурван сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.



Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Дэд Ерөнхийлөгч

Дэлхий даяар хурдацтай хөгжиж буй технологийн дэвшлийг банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийн зэрэгцээ харилцагчийн эрх ашиг, аюулгүй байдалд тулгарах эрсдэлүүдээс хамгаалах асуудлыг давхар бодолцох хэрэгтэй.



ЖОН БЕЛЛ

ХААН Банкны Гүйцэтгэх захирал

Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хялбараас гадна илүү аюулгүй авах боломжийг олгох нь технологийн хөгжлийг нэвтрүүлэхтэй дүйцэхүйц ач холбогдолтой зүйл юм.

ЦАХИМ БАНКНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ



КРИШИА РАЖАГОПАЛ

“Акати Консалтинг” компанийн Гүйцэтгэх захирал, мэдээлэл технологийн Олон улсын эксперт

Кибер гэмт хэргийн орон зай тэлж, гэмт хэрэгтнүүд улам ухаалаг болж байгаа учраас хэрэглэгчид өдөр тутамдаа анхааралтай байх хэрэгтэй.

ИЙДАЛ БА ТӨЛБӨРИЙН ЭРСДЭЛ” РУМ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



М.ЭНХБОЛД

*ХасБанкны Аюулгүй байдлын
удирдлагын газрын захирал*

Монгол Улс 2010 онд Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалаар Мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг анхаарч байгаа ч харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад төрийн оролцоо мөн чухал юм.



Б.БАНЗРАГЧ

*Монголбанкны Үндэсний цахим
гүйлгээний төвийн захирал*

Манайд 2017 оны жилийн эцсийн байдлаар 3.8 сая ширхэг карт байгаагийн 1.7 сая төлбөрийн карт идэвхтэй хэрэглэгдэж, жилийн хугацаанд картын гүйлгээний хэмжээ 6.6 их наяд төгрөгт хүрсэн нь бэлэн мөнгөнийхөөс их байгаа.

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЭРСДЭЛ



КРИС КАН

*Korea&Mongolia VISA компанийн
Эрсдэл хариуцсан захирал*

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдалд EMV технологи буюу чипэнд суурилсан картын технологийг олон улсын түвшинд хамгийн найдвартай гэж үзэж байгаа бөгөөд энэ нь залилантай тэмцэхэд хамгийн үр дүнтэй арга.

ЦАХИМ БАНК БОЛОН ТӨЛБӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ



А.ТУУЛ

*Монголбанкны Хууль, эрх зүйн
газрын Эрх зүйн хэрэгжилт, хяналтын
хэлтсийн захирал*

Өмнө нь харилцагчийг хамгаалах талаар зохицуулалтгүй байсан асуудлыг зохицуулж эхэлсэн нь сайн хэрэг. Банкуудын зүгээс Төв банкны зохицуулалтыг хүлээлгүйгээр өөрсдийнхөө хүрээнд харилцагчийн эрхийг хамгаалах ажлыг хийж эхэлсэн.



Б.БААТАРХҮҮ

*ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн
дарга, Цагдаагийн дэд хурандаа*

Пин код асууснаараа буруудахгүй, харин хариулснаараа эрсдэлд ордог. Тиймээс пин кодоо хэлэхгүй байх уриалга гаргаж байна.



Ж.ҮНЭНБАТ

*Монголын Банкны Холбооны
Гүйцэтгэх захирал*

Банкуудын үйл ажиллагаа явуулдаг хамгийн чухал оролцогч нь санхүүгийн хэрэглэгч.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

Өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 30.55 сая ам.долларын санхүүжилт хийгдэв

ХУУДАС

5

Индэр:

Монгол Улсын зээлжих зэрэглэл сүүлийн жилүүдэд анх удаа сайжирч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж эхэллээ

ХУУДАС

8

Ярилцлага:

Иргэдийн гомдол, маргааныг эрх зүйн хэмжээний хүрээнд зохицуулах боломж бүрдэнэ

ХУУДАС

12

Байр суурь:

Санхүүгийн хэрэглэгчийн эрх, ашиг Монголд

ХУУДАС

16

Улаанбаатарын зөвшилцөл:

“Улаанбаатарын зөвшилцөл”-ийн 8 зарчим

ХУУДАС

22

Асуулт, хариулт:

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас... /2018.04.26/

ХУУДАС

24

Монголбанк юу хийдэг вэ?

Найман хувийн инфляцид зорьсон нь инфляцийн дунджийг алгуур бууруулах алхам

ХУУДАС

29

Орон нутаг:

Баян-Өлгий аймаг дахь Монголбанк

ХУУДАС

32

Мөнгөн тэмдэгтийн түүх:

1941 оны мөнгөн тэмдэгт

ХУУДАС

34

Банкир:

Г.Дөлгөөн: Төрийн банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөхөд анхаарч ажиллаж байна

ХУУДАС

35

Дэлхийн эдийн засаг:

ОУВС “протекционист” гадаад худалдааны бодлогоос татгалзахыг уриаллаа

ХУУДАС

40

Санхүүгийн боловсрол:

Мөнгийг зөв удирдах нь мөнгөөр тасрахгүй байх арга

ХУУДАС

43

ОУВС, Дэлхийн банкны 2018 оны хаврын чуулга уулзалтын үеэр Монгол Улс эдийн засгийн өсөлтийг хангахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвшилцөв

ОУВС, Дэлхийн банкны хаврын ээлжит чуулга уулзалт 4-р сарын 16–22 өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо “Дэлхий нийтийн хүсэл тэмүүлэл болон сорилт бэрхшээлийг даван туулах нь” сэдвийн дор боллоо. Хаврын чуулга уулзалтад Монгол Улсаас Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Хаврын уулзалтын үеэр Монгол Улсыг хариуцах ОУВС, Дэлхийн Банкны удирдлага болон мэргэжилтнүүдтэй өнгөрсөн хагас жилийн хугацааны хамтын ажиллагааг дүгнэн санал солилцож, Монгол Улсын эдийн засаг, банкны систем, төсөв санхүүгийн 2018 оны эхний улирлын байдлыг танилцуулж, цаашдын арга хэмжээний талаар зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулсан юм.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдав



2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмтай тэмцэх тогтолцооны хоёр дахь удаагийн Харилцан үнэлгээг 2016-2017 онд хийж Монгол Улсыг эрчимтэй хяналтад оруулсан. Улмаар Монгол Улс 2018 оны 10 дугаар сар хүртэлх 15 сарын хугацаанд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг хүлээлгээд байсны дагуу ийнхүү хууль эрх зүйн тогтолцоогоо шинэчлэн сайжрууллаа.

Монголбанк 2017 онд 176.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллалаа

Монголбанк 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, хөндлөнгийн аудитын PWC Mongolia компаниар баталгаажууллаа. Тайлант хугацаанд 176.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 2012-2016 онд хуримтлагдсан 3.0 их наяд төгрөгийн алдагдлыг 2.8 их наяд төгрөг болгож бууруулаад байна. Үйл ажиллагааны үр дүн ашигтай гарахад, алт худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн ханштай нийцүүлснээр нийт 20 тонн алт худалдан авсан, дэлхийн зах зээл дээрх алтны үнэ оны эхнээс 10 орчим хувиар өссөн нь үнэт металлын арилжааны орлого нэмэгдэхэд мөн гадаад валютын нөөц өсөхөд нөлөөлөв. Гадаад валютын улсын нөөц 3 тэрбум ам.долларт хүрч, төгрөгийн ханш чангарснаар макро эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлж, улмаар Монголбанкны бодлогын шинж чанартай үйл ажиллагааны орлого, зарлагын урсгалыг сайжрууллаа.



Монголбанкны Хяналтын зөвлөл хуралдлаа



Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2018 оны 4 дүгээр сарын 26-нд болж, Хяналтын зөвлөлийн 2017 оны шийдвэр түүний биелэлтийн тухай болон Банк, Төв банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монголбанкны Хяналтын зөвлөл, Монголбанктай хамтран ажиллах, мэдээ, мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалтын талаар Монголбанкны ХЭЗГ-ийн хэлтсийн захирал Б.Эрдэнэхуягийн тайлбар мэдээлэл, Монголбанкны 2017 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК-ны аудиторуудтай санал солилцсон уулзалтын тухай мэдээлэл зэрэгтэй танилцлаа. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Хяналтын зөвлөлийн гишүүдийн саналыг тусган, шийдвэр гаргаж Монголбанкны удирдлагад хүргэх нь зүйтэй гэж шийдвэрлэв.

Цахим мөнгөний хэрэглээг журмаар зохицуулна

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тодорхойлсон цахим мөнгө, түүний үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, аюулгүй, найдвартай цахим мөнгөний системийг бий болгож хэрэглэгчийг хамгаалах зорилгоор “Цахим мөнгөний журам”-ыг шинээр боловсруулж, баталлаа. Энэхүү журмыг баталснаар цахим мөнгөний системд хэн, хэрхэн оролцох болон зөвшөөрөл авах үйл явцыг ойлгомжтой болгож, үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн эрх, үүргийг тодорхой болгоод зогсохгүй финтек, төлбөрийн системийн цаашдын хөгжлийг дэмжих юм.



“Мөнгөн тэмдэгтийн чиг хандлага, асуудлууд” сэдэвт сургалт зохион байгууллаа



Энэхүү сургалтаар мөнгөн тэмдэгтийн олон улсын өнөөгийн хөгжлийн чиг хандлага, бэлэн ба бэлэн бус төлбөрийн хэрэгслийн одоо ба ирээдүй, манай улсын бэлэн мөнгөний динамик хөдөлгөөн, бүтэц, түүний эдийн засгийн утга агуулга, онцлог шинж чанар, зүй тогтол зэрэг асуудлыг хэлэлцлээ. Мөн практик түвшинд хуурамч мөнгөн тэмдэгтийг ялгах үндсэн стандартын талаар ерөнхий ойлголтыг өгч, мөнгөн тэмдэгт ялгах шаблонуыг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах заавар зөвлөмжийг өгөх, сүүлийн үеийн хуурамч мөнгөн дэвсгэртүүдийн шинж чанаруудын талаар танилцууллаа. Мөн энэ үеэр хамгаалалтын элемент нь шинэчлэгдэж буй 5000-тын дэвсгэртийг танилцуулж, банкуудын АТМ машин цэнэглэлтийн алгоритмыг өөрчлөх боломж зэрэг асуудлуудыг өргөн хүрээнд хэлэлцүүлэв.

Орон нутагт алт худалдан авах нэг цэгийн үйлчилгээ нээнэ



Монголбанк Стандарт хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын Хяналтын газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран Дархан-Уул, Баянхонгор аймгуудад “Үнэт металлын сорьцын лаборатори” байгуулахаар боллоо. Үүнтэй холбогдуулж, Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбараар дамжуулан алт худалдан авах “Нэг цэгийн үйл ажиллагаа”-г нээх юм. Орон нутагт үнэт металлын сорьцыг тогтоох үйл ажиллагааг эхлүүлж, худалдан авах нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлснээр баруун болон төвийн бүсийн аймгуудад алт олборлогч компани, бичил уурхайчдын алт сорьцлуулах шат дамжлагыг багасгахын зэрэгцээ зах зээлийн өндөр үнээр худалдан борлуулах боломжуудыг бий болгоно.

Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн гишүүдтэй уулзалт хийв

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны дэргэдэх “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөл”-ийн дарга Б.Сэргэлэнг тус зөвлөлийн гишүүдийн хамт хүлээн авч уулзлаа. Уулзалтад Монголбанкнаас Нөөцийн Удирдлага, Санхүүгийн Зах зээлийн газрын захирал А.Энхжин, Эрдэнэсийн сангийн захирал П.Эрдэнэтуяа, Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн судлаач, эрдэмтдийн төлөөлөл оролцов. Уулзалтаар Монголбанкны Эрдэнэсийн санд хадгалагдаж буй түүхэн дурсгалт үнэт зүйлсийн зэрэглэлийг шинэчлэн тогтоох, мэргэжлийн шинжилгээ, судалгаа хийх, үзэсгэлэн зохион байгуулах болон цаашид хамтран ажиллах талаар санал солилцлоо.



МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД АНХ УДАА САЙЖИРЧ ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИТГЭЛ СЭРГЭЖ ЭХЭЛЛЭЭ



МОНГОЛБАНКНААС УЛИРАЛ БҮР ЭРХЛЭН ГАРГАДАГ
"МОНГО-САНХҮҮ-БАЯЛАГ" СЭТГҮҮЛИЙН ТАВ ДАХЬ
ДУГААРААС ОНЦЛОВ.

*"Хуулийн эх бичвэрийг хүлээн авах ёслол"-ын
нээлтэд Монгол Улсын Их Хурлын дарга
Миеэгомбын Энхболдын хэлсэн үг*

Улсын Их Хурлын 2017-2018 оны намрын чуулганаар батлагдсан Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай болон Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эх бичвэрийг Монголбанк 2018 оны гуравдугаар сарын 22-ны өдөр ёслол төгөлдөр хүлээн авлаа. Эх бичвэрийг хүлээлгэн өгөх ёслолд Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Дамба-Очир, УИХ-ын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, УИХ-ын гишүүн Я.Содбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон болон бусад байгууллагын төлөөлөл хүрэлцэн ирж оролцлоо.

Ёслолын үйл ажиллагааг Монгол Улсын Ардын жүжигчин, Соёлын гавъяат зүтгэлтэн, Төрийн хан хуурч Ц.Цэрэндорж морин хуурын татлагаар эхлүүлж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан нээж үг хэлсэн юм.

Тэрбээр Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Монголбанкнаас 2016 оноос эхлэн дунд хугацаанд хэрэгжүүлэх "Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг санаачилж, 2018 оныг банк, санхүүгийн салбарын шинэчлэлийн жил болгон зарлаж, бодлогын тодорхой зорилтыг тавин

хэрэгжүүлж эхлээд байгааг онцоллоо. Мөн банк, санхүүгийн салбарт сайн засаглал, оновчтой бодлого, зохицуулалтыг бий болгон, хууль, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх Монголбанкны санаачилгыг дэмжиж, хуулийн төслүүдийг УИХ-аар батлуулахад гар бие оролцсон нийт хүмүүст талархал илэрхийллээ.

Ийнхүү хүндэтгэлийн ёслолыг нээснээр УИХ-ын дарга М.Энхболд хуулийн эх бичвэрийг Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд гардуулан өглөө.

Тэрбээр эх бичвэрийг гардуулан өгөхдөө батлагдсан хуулиудын ач холбогдлын талаар онцлоод, хуулийн хэрэгжилтийг чанд сахин мөрдөхийн тулд нягт нямбай, хариуцлагатай ажиллахыг хүссэн юм.

Ингээд "Хуулийн эх бичвэрийг хүлээн авах ёслол"-ын нээлтэнд Монгол Улсын Их Хурлын дарга Миеэгомбын Энхболдын хэлсэн үгийг бүрэн эхээр нь Та бүхэнд хүргэж байна.

Эрхэм хүндэт Монголбанкны хамт олон, зочид оо,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье!

Монгол Улсын Их Хурлаас баталсан банк, санхүүгийн салбарын хуулиудын эх бичвэрийг хүлээн авах энэхүү арга хэмжээ нь албан ёслол гэхээсээ шинэ хуулиудыг гардан хэрэгжүүлэх гол хүмүүс болох Та бүхэн салбарынхаа бодлого, зохицуулалт, хэрэгжилтийн талаар санал бодлоо солилцох ажил хэрэгч уулзалт болно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү ярилцлагын эхлэл болгон Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар товч мэдээлэл өгч, банк, санхүүгийн салбарын асуудлаар зарим саналаа илэрхийлье.

Эрхэм хүндэт зочид оо,

Монгол Улсын Их Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал өнгөрсөн гурван удаагийн чуулганаар нийт 493 хууль, 143 тогтоол хэлэлцэн баталсан нь өмнөх Улсын Их Хурлын мөн хугацаанд шийдвэрлэсэнтэй харьцуулахад хуулийн тоо 83 хувиар, тогтоол 25 хувиар тус тус илүү байна. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүдийн хуралдааны ирц 46 хувиар сайжирч, тасалсан цаг 90 хувиар буурсан ажээ. УИХ-ын Байнгын хороод давхардсан тоогоор 196 гишүүнтэй 31 ажлын хэсэг байгуулан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан нь өмнөх мөн үеэс гишүүдийн тоо 23 хувиар, ажлын хэсгийн тоо 41 хувиар өссөн байна.

Улсын Их Хурлын хэлэлцэн баталсан 493 хуулиас нэн чухалд тооцогдох гурвыг нь өнөөдөр Та бүхэнд хүлээлгэн өгч байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь гадаад зах зээлээс илүүтэй төрийн бодлого, засаглалын түвшин, институцийн хөгжил, хүний нөөцийн чадавхи, хариуцлагын түвшнээс голчлон хамаарч байна.

Тиймээс Төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцыг олон улсын зарчимд нийцүүлэх, арилжааны банкны сайн засаглалыг бэхжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хадгаламжийн даатгалын суурь зарчмыг нэвтрүүлэх, банкны салбарын хүндрэлийг даатгалын механизмаар даван туулах тогтолцоог бүрдүүлэх зэрэг олон чухал асуудлыг эдгээр хуульд тусгасан юм.

Ингэснээр албан тушаалтан дураар авирлах, аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал үүсгэх, татвар төлөгчдийн мөнгөөр хариуцлагагүй банкны өмнөөс хариуцлага хүлээх, харилцагчдын эрх ашиг хөндөгдөх зэрэг явдлыг таслан зогсоох боломж бүрдлээ. Эдгээр хууль батлагдсанаар эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдал, банкны салбарын өрсөлдөх чадвар, санхүүгийн зуучлалын үр ашигт эергээр нөлөөлнө гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын эдийн засагт нааштай өөрчлөлт гарч эхэлснийг Та бүхэн мэдэж байгаа. УИХ-аар баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд ОУВС-тай хамтран макро эдийн засгийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч байна.

Бид нэгдмэл төсвийн бодлого баримталж, өрийн удирдлагыг сайжруулан, төсвийн алдагдлыг хоёр дахин бууруулж, нэн тулгамдсан 1.1 тэрбум ам.долларын гадаад өрийг шийдвэрлэлээ. Гадаад худалдааны тэнцлийн ашиг 20 хувиар нэмэгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.5 тэрбум ам.доллар, гадаад валютын албан нөөц 3.0 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл, гадаад өрийн тогтвортой байдал сайжирлаа.

Эдийн засагт ийнхүү бодлогын өөрчлөлт, бодит үр дүн гарснаар Монгол Улсын эзэлжих зэрэглэл сүүлийн жилүүдэд анх удаа сайжирч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж эхэллээ. Энэ дашрамд уг хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа Монголбанк, олон улсын шаардлагыг давж сайн үнэлгээтэй гарсан банкны салбарын хамт олонд талархлаа илэрхийлье.

Мэргэжил нэгт эрхэм нөхөд өө,

Монгол Улсын эдийн засаг уналтаас өндөр өсөлт рүү, эргээд уналт, хүндрэл рүү орж байсан гашуун түүх бий. Үүнийг давтаж болохгүй. Иймд одоогийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах, урт хугацаанд гадаад зах зээлийн өөрчлөлтөөс дархлаатай, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийн хөгжлийн загвар руу шилжих ёстой. Энэ зорилтын хүрээнд Та бүхнийг дараах гурван асуудлыг анхаарч ажиллаасай гэж хүсч байна.

Нэгдүгээрт, ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд тохиролцсон макро эдийн засгийн болон банкны бүтцийн өөрчлөлтийн бодлогыг үргэлжлүүлж, банкны салбарын шинэчлэлийг тууштай хийх нь зүйтэй байна. Арилжааны банкны активын чанарын иж бүрэн үнэлгээний сайн үр дүнг улам баталгаажуулан, шинээр батлагдсан хуулиудыг тууштай хэрэгжүүлж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй.

Түүнчлэн “Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөсөн бусад хуулийн төслүүдээ боловсруулан Улсын Их Хурлын хаврын энэ чуулганд өргөн барих нь

зүйтэй. Улсын Их Хурал эдгээр хуулийг цаг хугацаанд нь хэлэлцэн батлахад бэлэн байна.

Хоёрдугаарт, сэдэвчилсэн буюу салбарын судалгааны ажлыг нэмэгдүүлж, бодлогын зөвлөмжөөр Улсын Их Хурал, Засгийн газрыг хангах ажлаа эрчимжүүлэх нь чухал байна.

Монголбанкны хүний нөөц, санхүүгийн боломжид тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, дархлааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх бүтцийн өөрчлөлтийн бодлогын судалгааг гүйцэтгэж, хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлох шаардлага гарч байна. Тухайлбал, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээнд ямар статистик, мэдээлэл дутагдаж байгаа, аль шатанд гацаа хүндрэл үүсч байгаа, хувийн хэвшлийн санхүүжилтийн эрсдэл, өртгийг яаж бууруулах, төрийн оролцоог хэрхэн оновчтой болгох, энэ зах зээлийн дэд бүтцийг хэрхэн сайжруулж, гадаад зах зээлд ямар арга хэлбэрээр нэвтрэх, энэ нь эргээд үндэсний хөгжлийн бодлоготой хэрхэн уялдах зэрэг маш олон асуудлыг цогцоор судалж, оновчтой шийдлийг гаргах нь тулгамдсан асуудал болж байна.

Монголбанк, банкны салбарын мэргэжилтнүүдтэйгээ нийлээд энэ бүх асуултын хариулыг бодитой тооцоо, судалгааны үндсэн дээр бодлогын зөвлөмж болгон гаргаж ирнэ гэдэгт итгэлтэй байна.

Гуравдугаарт, Валютын ханш, зээлийн хүү зах

зээлийн зарчмаар бодитой тогтох зарчмыг тууштай баримталж, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг багасгах талаар илүү идэвх, санаачлагатай ажиллах шаардлагатай байна. Макро эдийн засгийн орчин сайжрахын хэрээр үнийн савалгаа тогтворжиж, зарим нь буурч байгаа хэдий ч бизнес эрхлэгчдийн санхүүгийн зардал, эрсдэл өндөр хэвээр байна.

Монгол Улс "Олон улсын өрсөлдөх чадварын 2017 оны тайлан"-гаар 137 орноос санхүүгийн салбарын хөгжлийн үзүүлэлтээр 129-т, үүний дотор банкны салбарын эрүүл мэндийн үзүүлэлтээр 126-т байна. Түүнчлэн бизнесийн хөгжлийн түвшнээр 123-т байгаа нь бид асуудлын шалтгааныг бүрэн тодорхойлж, эмчилж чадахгүй байгааг харуулж байна. Бизнесийн орчин, зээлжих зэрэглэлийн ийм үнэлгээтэй байгаагийн учир шалтгааны талаарх олон нийтийн ойлголт, мэдээлэл тэгш бус байгаагаас шинж тэмдгийг түр эмчлэх буюу үнийг хүчээр тогтоох арга зам руу халтирах хэмжээнд хүртэл очоод байна.

Иймд Та бүхнийг зөвхөн банкны салбарыг биш харилцагч бизнесийн салбар, баялаг бүтээгчдийг хамтад нь анхаарч, бизнесийн боломж, ур чадварыг нь хөгжүүлэхэд тусалж дэмжих, дагаад өөрсдөө өсч дэвжих бодлогыг баримтлан манлайлан ажиллаасай гэж хүсч байна.

Та бүхэн батлагдсан хуулиа чанд мөрдөн улс орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулахыг хүсье!

МОНГОЛБАНК ДӨРӨВДҮГЭЭР САРД 988.8 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2018 оны 4 дүгээр сард 988.8 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 779.4 кг алт авч байснаас 209.4 кг-аар их буюу 27%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Харин Монголбанк 2018 оны эхний 4 сард 3.3 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 3 тонн алт авч байснаас 257 кг-аар их буюу 8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 4 дүгээр сарын байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 102,536.15 төгрөг байлаа.





График 1. 1990-2018 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



График 2. 2018 оны 4 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг нэвтрүүлсэнээс хойш 2018/4/27-ны хооронд 388.5 сая ам.долларын, 91.1 сая юанийн нийт 681 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.





ИРГЭДИЙН ГОМДОЛ, МАРГААНЫГ ЭРХ ЗҮЙН ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИЦУУЛАХ БОЛОМЖ БҮРДЭНЭ

Монголбанкны Хууль эрх зүйн газрын захирал Б.Ганбатыг ярилцлагын буландаа зочноор урив.

АЖЛЫН ТУРШЛАГА

2016 оноос
Монголбанкны Хууль эрх
зүйн газрын захирал

2016: Монгол Улсын
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газарт, Газрын
дарга

2013-2015: Дэлхийн
банкны Олон салбарын
техник туслалцааны
төслийн хуулийн эксперт

1995-2013: Сангийн яам,
Хуулийн зөвлөх, Хуулийн
хэлтэст мэргэжилтэн,
ахлах мэргэжилтэн,
хэлтсийн дарга, Газрын
орлогч дарга, Газрын
дарга

1990-1995: Дорноговь
аймаг, нийслэлийн
Баянгол дүүргийн
Цагдаагийн хэлтэст
төлөөлөгч, мөрдөн
байцаагч

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ

2008: Англи Улсын
Хуулийн сургуульд хууль
зүйн магистр

1990: ЗХУ-ын Москва хот,
Дотоод явдлын яамны
академид хуульч

**Монголбанкнаас санаачлан
хэрэгжүүлж буй "Санхүүгийн
хэрэглэгчийн эрхийг хамгаалах
аян" хэрхэн үргэлжилж байгаа
талаар юуны өмнө мэдээлэл
өгнө үү?**

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах аян маань 2018 оны 1 дүгээр сараас эхэлж, 5 сарын хугацаатай үргэлжлэх юм. Өнгөрсөн хугацаанд аяны хүрээнд хэд хэдэн томоохон ажлууд хийгдлээ. Тухайлбал, Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран өргөн хүрээнд тэмдэглэллээ. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг НҮБ-ын шийдвэрээр дэлхий нийт 1983 оноос жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдөр тэмдэглэдэг уламжлал нэгэнт тогтсон байна. Манай улсын хувьд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас санаачлан 2003 оноос эхлэн энэ өдрийг тэмдэглэн ирсэн байдаг. Энэ жилийн хувьд онд тус өдрийг дэлхий нийтээрээ "Цахим

худалдаан дахь хэрэглэгчийн эрх" сэдвийн хүрээнд тэмдэглэж байна. Энэ үеэр Монголбанкны Хууль, эрх зүйн газар, Төлбөр тооцооны газар, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газраас тус тус өөрсдийн үйл ажиллагааны талаар илтгэл, танилцуулгыг хийсэн. Мөн Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран "Санхүүгийн хэрэглэгчийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдал" сэдэвт хэлэлцүүлгийг Монголбанкин дээр амжилттай зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод, даатгалын компаниудын төлөөлүүд оролцож өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн. "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян" нь сар бүр тус тусдаа тавигдсан сэдвийн хүрээнд зохиогдож байгаагаараа онцлог л доо. 4 дүгээр сарын хувьд авч үзэхэд "Цахим худалдаа

буюу төлбөрийн карт түүний зохистой хэрэглээ, аюулгүй байдал" гэсэн сэдвийн дор санхүүгийн хэрэглэгчдэд зөвлөгөө мэдээллийг өгч ажиллаж байна. Энэ сард хийгдсэн бас нэг томоохон ажил гэвэл тус аяны хүрээнд ХААН банкт хамтран 4 дүгээр сарын 26-ны өдөр "Цахим банкны аюулгүй байдал ба төлбөрийн эрсдэл" форумыг амжилттай зохион байгууллаа. Тус форумд Монголбанк, Монголын банкны холбоо, Олон улсын мэдээлэл технологийн олон улсын эксперт, Монгол-БНСУ-ыг хариуцсан Виза интернэйшнл компанийн эрсдэл хариуцсан захирал, Төлбөрийн картын олон улсын экспертүүд уригдан оролцсон томоохон арга хэмжээ болсон.

Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ямар зүйл дээр нийтлэг зөрчигддөг вэ? Түүнийг шийдвэрлэх ямар арга замууд байдаг вэ?

Санхүүгийн хэрэглэгчийн эрх зөрчигдөх хамгийн гол шалтгаан бол санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн мэдлэг, боловсрол дутмаг байдлаас болдог. Мөн нөгөө талаас санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар өөрөө хангалттай мэдээлэлтэй ч түүнийгээ хэрэглэгчид бүрэн тайлбарлаж ойлгуулдаггүйтэй холбоотой. Үүнээс болж хэрэглэгчид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч чадахгүй байна. Тиймээс харилцаанд оролцож буй хоёр талын эрх ашгийг тэнцвэртэй

байлгахад "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян"-ы гол зорилго оршиж байгаа юм. Монголбанк энэ аяныг 5 сарын хугацаатай зохион байгуулаад дуусгахгүй. Аяны

Сүүлийн үед дэлхийн улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр илүү нухацтай хандаж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээс эхлээд, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, бизнесийн сайн арга барилыг мөрдүүлэх, маргааныг боловсронгуй аргаар шийдвэрлэх зэрэг чиглэлээр хурдацтай дэвшлүүдийг хийх болсон.

хүрээнд гаргахаар төлөвлөсөн хамгийн том ажил бол санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлан хуультай болох зорилго тавьсан байгаа. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг хэдийнээ ажлаа эхлүүлчихсэн, аяны төгсгөлд хуулийн төслийг бэлэн болгохоор ажиллаж байна.

4 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай заалт тусгасан байгаа шүү дээ. Гэтэл дахин бие даасан хуультай байх шаардлагын тухай тайлбарлана уу?

Монголбанкнаас Төв банк (Монголбанк), Банкны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 11

дүгээр сард УИХ-д өргөн барьсны дагуу 2018 оны 2 дугаар сард батлагдаж, 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж албан ёсоор дагаж мөрдөгдөж эхэлсэн. Энэ удаагийн

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд нэмж оруулсан нэг онцлох зохицуулалт бол Монголбанкны үйл ажиллагааны чиглэл дотор "банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэсэн заалт орсон. Ингэснээр Монголбанк өөрийн эрх хэмжээний хүрээнд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалахад шаардлагатай бодлого боловсруулах, хяналт зохицуулалтыг хийх мандаттай болсон гэж ойлгож болох юм. Монгол Улс өнөөдрийг хүртэл Хэрэглэгчийн эрхийг

хамгаалах тухай ганцхан хуулиар нийт хэрэглэгчийн эрхийг хамгаалж байгаа. Монголбанкнаас санаачлан зохион байгуулж буй "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян"-ы хүрээнд боловсруулан гаргахаар төлөвлөсөн "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хууль"-ийн төсөл нь зөвхөн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүртэгч иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байх тул Монгол Улсын хувьд хэрэглэгчийн эрх ашгийг төрлөөр нь ялгаж авч үзсэн анхны хууль байх юм. Уг хуулийг тусад нь салгах болсон гол шалтгаан бол Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 94.5 хувийг эзэлдэг банкны салбарын хэрэглэгчид өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа төдийгүй Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг

хамгаалахад эдгээр массыг илүү мэдлэгжүүлж, санхүүгийн сахилга баттай болгохоос гадна санхүүгийн хэрэглэгч-санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоёрын хоорондын харилцаанаас үүсэх гомдол, маргааныг илүү альтернатив байдлаар зохицуулахад оршиж байгаа юм.

Ийм хуультай болсноор гол нь маргаан шийдвэрлэх үйл явцыг тодорхой болгож өгөх үү?

Тэгнэ. Монголбанкны хувьд өмнө нь иргэдээс ирүүлсэн банктай холбоотой гомдол, маргааныг хөндлөнгөөс шууд шийдвэрлэх эрх зүйн боломжгүй байдаг байсан бол уг хууль гарснаар Монголбанкны дотоод бүтэц дотор шинэ нэгж байгуулагдаж, энэ нэгж нь иргэдийн гомдол, маргааныг эрх зүйн хэмжээний хүрээнд зохицуулах боломжоор бүрдэх юм. Тухайн нэгж нь банкны салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад илүү мэргэшсэн, салбараа мэддэг мэргэжилтнүүдээс бүрдэнэ гэж үзэж байгаа.

Үүний цаад ач холбогдол нь эдийн засагт хэрхэн тусгалаа олох вэ?

Гол ач холбогдол нь санхүүгийн хүртээмжийг дээшлүүлж, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн тулгуурыг бүрдүүлэх, нөгөө талаар санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ил тод, ёс

зүйтэй үйлчилгээгээр дамжуулан санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн зохистой хэрэглээ өсөн нэмэгдэхэд чиглэгдэнэ гэж харж байна.

Олон улсад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал яагаад хүчтэй тавигдах болсон бэ?

2008 оны Дэлхийн санхүүгийн хямралын дараа улс орнууд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал хүчин зүйлсийн нэг нь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах, түүний санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх явдал юм гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Тиймдээ ч сүүлийн үед дэлхийн улс орнууд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр илүү нухацтай хандаж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхээс эхлээд, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах, бизнесийн сайн арга барилыг мөрдүүлэх, маргааныг боловсронгуй аргаар шийдвэрлэх зэрэг чиглэлээр хурдацтай дэвшлүүдийг хийх болсон. Манай улс ч дэлхийн бусад улсын адил үүнд санаа тавих цаг нь болсон тул Монголбанк АХБ-тай хамтран 2017 онд "Санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих" төслийн бүрэлдэхүүн хэсэг болох "Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь" дэд төслийг амжилттай хэрэгжүүлж

дуусгасан. Уг төслийн хүрээнд нийт үндэсний 3 томоохон хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төслийн үр дүнд Санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зарчим, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох олон улсын шилдэг туршлагаас гадна Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо, түүнийг шинэчлэх талаарх зөвлөмжийг өгсөн байгаа.

Азийн хөгжлийн банкнаас манайд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хүрээнд өгсөн зөвлөмжийн дагуу ажлын явц ямар байна вэ, Энэ хүрээнд хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал бий юу?

АХБ-аас өгсөн зөвлөмжийг бид дахин судлан үзээд өгсөн бүх зөвлөмжийг ажил хэрэг болгон Монголбанкнаас санаачлан боловсруулж буй Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөлд тусгаад явж байгаа. Мэдээж хууль шинээр боловсруулахад амаргүй тул чанартай сайн хууль гаргахын төлөө бусад төрийн зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллах, олон нийтийн санал, асуулгыг авах гээд бүхий л тал дээр ажиллах шаардлагатай байгаа.

Ярилцсанд баярлалаа.




Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоо



Олон Улсад



2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа



Дэлхий дахинд санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах шаардлага тулгарсан

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцоо өнөө цагт



Санхүүгийн хэрэглэгчийг эрх ашгийг хамгаалах гэдэг нь

Санхүүгийн тогтвортой байдалтай шууд хамааралтай

Хяналт шалгалтын тогтолцоо



Зохистой харьцааг хангуулах хяналт шалгалтыг



Хэрэглэгчийг хамгаалах хяналт шалгалттай хослуулан хэгжүүлэх нь илүү үр нөлөөтэй

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, АШИГ МОНГОЛД

Энэ асуудлаар холбогдох байгууллагуудын төлөөллийн байр суурийг толилуулж байна.

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЧИЙН ТӨЛӨӨ
ГАЗРЫН ДЭД ДАРГА **Н.БЯМБАДОРЖ**:

Ажиглаж байхад банк санхүүгийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын эрх ашиг, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг илүү анхаараад, үйлчлүүлж буй хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал нэлээд хоцрогдсон байгаад байна. Харин сүүлийн жилүүдэд ШӨХТГ болон төрийн холбогдох хяналтын байгууллагууд нэлээд өргөн хүрээнд авч үзэж эхэлж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Яагаад гэвэл, энэ хүрээнд санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хурцаар тавигдаж байна. Энэ салбарын нэг учир дутагдалтай тал нь ерөөсөө эрх зүйн зохицуулалт байхгүй явж ирсэн. Тийм учраас санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал бараг яригдахгүй, үндсэндээ хаягдсан гэсэн үг. Өнгөрсөн жилээс эхлээд Монголбанкн дээр Азийн хөгжлийн банкны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн. Ингэснээр санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал нэлээд сөхөгдөж байна. Одоогийн хууль, тогтоомжид бол санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт бараг үгүй гэж болно. Харин энэ оны нэгдүгээр сард Төв банкны тухай хуульд өөрчлөлт орж, нэг зүйл нэмэгдсэн нь банкны харилцагчид болон хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг төв банк хариуцна гэсэн заалт юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ
ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.АРИУНАА:

Санхүүгийн зохицуулах хорооны бүтцэд хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах нэгж ажилладаг. Энэ нэгж нь хэрэглэгч, үйлчлүүлэгчээс нэг үгээр бол хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчээс ирүүлж байгаа гомдол маргааныг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, хариу өгч байна. Сүүлийн жилүүдэд өргөдөл гомдлын тоо өсөх хандлагатай байгаа ч өнгөрсөн жилийн хувьд харьцангуй

буурсан. Буурсан шалтгаан нь манайд хандсан өргөдөл, гомдлыг манайд хамаарах эсэхээс нь ялгах, гомдол үүсэх нөхцөл байдлыг дор нь шийдвэрлэх, танин мэдэхүйн шинжтэй асуудлыг тайлбарлах, зөвлөгөө өгөх байдлаар ажилласантай холбоотой. Өнгөрсөн 2017 онд манайд 270 орчим өргөдөл гомдол ирсэн байна. Үүний дийлэнх нь буюу 54 хувь нь даатгалтай холбоотой байгаа бол үнэт цаастай холбоотой өргөдөл гомдол 30 орчим хувийг, үлдсэн нь ББСБ, ХЗХ-той холбоотой байна. Ер нь бол Монгол Улсын хэмжээнд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хэн хамгаалах вэ гэдэг асуудал бий. Энэ талаар Азийн хөгжлийн банкны судалгаа ч хийгдсэн. Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд олгогдсон үүргийнхээ хүрээнд банкнаас бусад санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрхийг Санхүүгийн зохицуулах хороо хамгаалахаар зохицуулагдсан байдаг.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ **Ж.ҮНЭНБАТ**:

Банк үйл ажиллагаа явуулж буйн гол зарчим нь бусдын мөнгийг өөр дээрээ хадгалаад өөрийнхөө нэрийн өмнөөс бусдад зээлдүүлдэг. Тэгэхээр бидний хувьд санхүүгийн хэрэглэгчид гэдэг хамгийн чухал оролцогчид. Тэдгээрийн эрх ашгийг яаж хамгаалж, банкны үйл ажиллагаагаа ойлгуулж, өнө мөнхийн харилцагчид байлгах вэ гэдэг банк бүрийн санаа тавьдаг гол зүйл юм. Тэгэхээр тэр хүмүүс буюу харилцагчид маань илүү сайн боловсорсон баймааж нь банктай эн тэнцүү хэлцэлд орох боломж бүрдэх юм. Энэ чиглэлээр санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг. Хэрэглэгчдэд өөрсдийнх нь хэрэгцээт мэдээллээс гадна улс орны эдийн засаг, банк санхүүгийн салбарын тухай ойлголтыг өгөөд зогсохгүй, мөн хэрэглэгч бүтээгдэхүүн сонгож авахдаа ямархуу чиглэлээр ажиллах вэ, ямар илүү боломж байна вэ гэдгийг зөв, бодитой сургахыг, хамт хөгжихийг эрмэлздэг. Банк санхүүгийн байгууллагын гаргаж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний

талаар зөв мэдээлэлтэй, өөрийнхөө эрсдэлийг зөв тооцсон байж гэмээнэ хоорондын итгэлцэл нэмэгдэнэ. Итгэлцэл дээр тогтдог бизнест энэ харилцаа илүү бэхжиж байж, банкны болон бизнесийн салбар илүү хөгжих бололцоотой юм.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
АРБИТРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУУЛЬЧ, АРБИТРЧ, ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧ
Ч.ГҮНЖДАГВА:

Арбитраар шийдвэрлэж байгаа хэрэг маргааны багагүй хувийг иргэд хоорондын, аж ахуйн нэгж хоорондын зээлийн гэрээнээс үүссэн маргаан эзэлж байгаа бөгөөд банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын гэрээний маргааныг арбитраар шийдвэрлэх боломжийг Монгол Улсын Арбитрын тухай 2017 оны хуулиар олгосон. Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д "Хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны тухайд арбитрын хэлэлцээрийг гагцхүү маргаан үүссэний дараа талууд бичгээр тусад нь байгуулах бөгөөд арбитрын ажиллагааны харьяаллыг заасан байна" гэжээ. Мөн тус арбитрын Санхүүгийн маргаан шийдвэрлэх дүрмээр "... банк санхүүгийн байгууллага хооронд эсвэл банк, санхүүгийн бүхий л төрлийн хэрэгсэл, баримт бичгийг худалдах буюу шилжүүлэх, энгийн буюу барьцаат зээл, хөрөнгийн баталгаа, банкны баталгаа, аккредитив, сангийн хэлцэл, бонд, шилжих эрхтэй санхүүгийн хэрэгсэл, факторинг, банк хоорондын төлбөр барагдуулахтай холбоотой бүх төрлийн маргаан..."-ыг шийдвэрлэх бөгөөд банк санхүүгийн маргааныг хараат бус, шударга, шуурхай шийдвэрлэх ажиллагааг зохицуулдаг. Иймээс санхүүгийн хэрэглэгч, оролцогчдын хоорондын гэрээнээс үүссэн аливаа маргааныг арбитраар шийдвэрлэх боломжтой. Дэлхий нийтийн хандлага ч энэ чиглэл рүү явж байна. Арбитрын гарсан шийдвэр эцсийн бөгөөд давж заалддаггүй тул санхүүгийн маргааныг арбитраар шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

12 ЖИЛИЙГ ДҮРСЭЛСЭН ИХ ГАРЫН МӨНГӨН АЯГА

Модон аягыг мөнгөөр бүрж, гаднах ёроолын төвд нь луу, эргэн тойронд нь 12 жилийн амьтдыг хөөмөлдөж чимэглэсэн хийцтэй.

XX зууны дунд үеийн Төв халхын хийц
Хоршооллын сайн дурын урчуудын бүтээл

Жин: 844 гр, голч 20.5 см



**А.ТУУЛ**

ХЭЗГ-ийн Эрх зүйн хэрэгжилт,
хяналтын хэлтсийн захирал

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ

Тагаад чухал үзэж

Санхүүгийн хэрэглэгч гэж хэн бэ гэдэг асуулт юуны өмнө тавигдах биз ээ. Энэ бол маш энгийн ойлголтын хүрээнд тайлбарлагдах зүйл. Ямарваа санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг өөрийн болон гэр бүлийн хүрээнд буюу хувийн хэрэгцээндээ авч байгаа хэрэглэгчийг хэлж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл, мөнгөн хадгаламж хийх, зээл авах, даатгалд хамрагдах, төрөл бүрийн төлбөрийн карт эзэмших зэргээр санхүүгийн олон нэр төрлийн бүтээгдэхүүнүүдээс сонголт хийж хэрэглэдэг шүү дээ. Иймээс хүн бүр санхүүгийн хэрэглэгч байх бүрэн боломжтой. Харин энэхүү харилцааны улмаас 2 тал аливаа хэлбэрээр хохирол амсахгүй байх нь чухал асуудал учраас санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудалд улс орнууд онцгой анхаарлаа хандуулах болжээ.

2008 оны дэлхий дахиныг хамарсан санхүүгийн их хямралаас үүдэн дүгнэлт хийсний үндсэн дээр санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай асуудал хүчтэй хөндөгдсөн гэж үздэг. Учир нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт болон, түүнээс үүссэн харилцааны үр дүн нь санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц амин чухал үзүүлэлт болдог. Тиймээс хэрэглэгч санхүүгийн

бүтээгдэхүүн үйлчилгээ авахдаа мэдлэгтэй, мэдээлэлтэй хандснаар сонголтоо оновчтой зөв хийдэг байх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тухайн харилцагчийг шаардлагатай мэдээллээр бүрэн хангаж, үйл ажиллагаагаа ойлгомжтой тайлбарлах зэргээр харилцагч сонголтоо буруу хийснээс үүдэн гарах хохирол, эрсдэлээс сэргийлэх, эдгээрийг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох асуудлууд тавигдах болсон юм.

Хөгжиж буй улс орнуудад, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь, олон улсын санхүүгийн салбарт байр сууриа олоход чухал үүрэг гүйцэтгэх гол хэрэгсэл болж байна. Ихэнх улс оронд, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоонд тавих хяналт нь банкны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зохицуулагч байгууллагын үйл ажиллагааны нэг гол бүрэлдэхүүн хэсэг болсон байна.

Манай улсын хувьд 2012 оны 1-р сард Сангийн яамнаас (СЯ) санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Дэлхийн Банкны техникийн туслалцаа авах хүсэлт гаргасны дагуу 2012 онд Дэлхийн банкны ажлын хэсэг Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын



оношилгоо дүгнэлт (ХЭАХССБ) хийхээр Монгол Улсад томилогдон ажилласан байдаг.

Дэлхийн банкнаас өгсөн зөвлөмжид манай улсын санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн хүрээ нь нэгдмэл бус, тодорхойгүй тул салбарын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах дэлгэрэнгүй заалтуудыг нэмж тусгах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн давхцлыг арилгахын тулд холбогдох бусад хуулийн үйлчлэх хүрээнээс санхүүгийн салбарыг хасах, МБ-ны дотоод бүтцэд ерөнхий хяналт, зохицуулалтаас тусдаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах шинэ нэгж байгуулах мөн СЗХ-ны хяналт тавих чиг үүрэг бүхий газруудад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах баг бий болгох замаар МБ, СЗХ-ны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүрэг, оролцоог бэхжүүлэх зүйтэй гэж зөвлөсөн байдаг.

Монгол Улсад зохицуулалттай сайтай бөгөөд хүн бүрт хүрч ажилладаг салбарын нэг бол яах аргагүй банкны салбар юм. Өнөөдөр Монгол Улсын санхүүгийн системийн 95.4 хувийг банкны салбар эзэлж байна. Банк, түүнд хамаарах үйл ажиллагаа Монголбанкны зохицуулалт, хяналтад байдаг. Тийм ч учраас банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд оруулсан нэмэлт,

өөрчлөлтөөр санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар тодорхой заалт оруулж өгсөн. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор тус хуулийн 5-р зүйл буюу Монголбанкны үйл ажиллагааны чиглэлд “Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн заалт нэмэгдсэн бөгөөд 2018 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэ зохицуулалтаар Монголбанкны дотоод бүтцэд банкны салбар дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн хяналт шалгалтын бие даасан нэгж байгуулагдах боломжтой болж байна.

2016 оны 3 дугаар сард Монголбанк, Азийн хөгжлийн банкны (АХБ) хооронд Монгол Улсын Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах төсөлд дэмжлэг үзүүлэхээр, хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулж, 2016 оны 11 дүгээр сард Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Сангийн яам (СЯ), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-ын төлөөлөл бүхий гарааны уулзалтаас гарсан саналууд дээр тулгуурлан цаашид Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах төслийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, төсөл хэрэгжүүлэгчээр Монголбанк ажилласан юм.

Санамж бичгийн хүрээнд 2017 оны 3 дугаар сард “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зарчим, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох олон улсын шилдэг туршлага” сэдэвт сургалт, 2017 оны 5 дугаар сард Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах Монгол Улсын өнөөгийн хууль тогтоомж, зохицуулалтад шинжилгээ хийж, зөвлөмж өгөх Үндэсний хэмжээний уулзалт семинар, 2017 оны 10 дугаар сарын 12-нд “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зохицуулалт, хяналт: Банк, санхүүгийн зохицуулагчийн үүрэг” сэдвээр олон улсын бага хурлыг зохион байгуулж, Монголбанк, СЯ, СЗХ, ШӨХТГ, МБХ болон мэргэжлийн холбоод, банк, банк бус санхүүгийн байгууллагын төлөөллүүд болон Австрали, Итали, Япон, Хятад, Өмнөд Солонгос, Армен, Индонези зэрэг улсын салбарын тэргүүлэх мэргэжилтнүүд оролцож, манай улсын банк, санхүүгийн салбарын төлөөллүүд, зохицуулагч байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдийг хамарсан, харилцан туршлага солилцсон үр дүнтэй арга хэмжээ болж өнгөрсөн.

Төсөл хэрэгжүүлэгч Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх талаарх зөвлөмжийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх тогтолцоог зохицуулагч байгууллагууд болоод санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн дотоод бүтцэд бий болгохыг бидэнд зөвлөсөн.

Мөн санхүүгийн зохицуулагч байгууллага болон шүүх, засаглалын тогтолцооноос гадуур санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, хэрэглэгчийн хооронд үүссэн аливаа маргааныг бие даасан хараат бус байдлаар, аль болох өртөг багатайгаар хурдан шуурхай шийдвэрлэхээр ажилладаг санхүүгийн байгууллагууд буюу омбудсманыг бий болгох, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх зэрэг манай улсад хэрэгжүүлж болохоор хөгжингүй болоод хөгжиж буй орнуудын олон практик зөвлөмжүүдийг өгсөн билээ.

Санхүүгийн тогтвортой байдалд банкны тогтолцооны тогтвортой байдал төдийгүй санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцоо чухал үүрэгтэй гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрөх болсон өнөө үед санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах шинэ эрх

зүйн орчинг бүрдүүлж, хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээг тэлэхэд тус салбарыг зохицуулах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах дэлгэрэнгүй заалтуудыг нэмж тусгах шаардлагатай байна. Цаашлаад Монгол Улсын хэмжээнд санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг зохицуулсан тусгайлсан хуультай болох нь зүйтэй байна гэж үзээд Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачлагаар Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад хуулийн хэрэгцээ шаардлагыг судлах судалгааны ажил хийгдэж байна.

Монголбанкны зүгээс 2018 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 5 сарын хугацаатай “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяныг зохион байгуулж байна. Манай улсад анх удаа санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр хэрэгжиж буй энэхүү аян нь нийт санхүүгийн салбарыг хамарч байгаа бөгөөд санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлэх, уг харилцаанд оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах, хяналт, зохицуулагч байгууллагын гүйцэтгэх үүргийг боловсронгуй болгохыг зорьж байна. Аяныг Монголбанк, түүний орон нутаг дахь нийт 17 хэлтэс, салбар, манай улсад үйл ажиллагаагаа явуулж буй 14 банк, мөн түүний орон нутаг дахь нэгжүүд, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Монголын ипотекийн корпораци, Хадгаламжийн даатгалын корпораци, Бичил санхүүгийн хөгжлийн сан, төрийн болон төрийн бус бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.

Энэ аянаас бид хэдэн хэдэн үр дүнг хүлээж байгаа бөгөөд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хийгдэж буй бодлогын чухал асуудлыг олон нийтэд мэдээлэх, энэ хүрээндээ олон нийтийн саналыг сонсох, хамгийн гол нь санхүүгийн хэрэглэгчид бүтээгдэхүүний талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар олж авах, улмаар сонголтоо зөв хийхэд туслах, хэрэглэгч санхүүгийн сахилга батыг ягштал баримталдаг болсноор санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд болон улс орны санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦЛИЙГ САНАЛ БОЛГОХ НЬ:

ХӨГЖИЛД ХҮРГЭХ БОДЛОГЫН ЖОР

Зарчим 1

Засаглал, институцийг сайжруулах,
чанарыг бэхжүүлэх, авлигын эсрэг
тууштай тэмцэх



Хүчтэй, сайн институци нь байгалийн баялгийн хараалаас зайлсхийж, тогтвортой өсөлтийг хангах боломжийг олгох бөгөөд үүнийг бүрдүүлэх нь авлигаас ангид, хуулийг ёсчлон хэрэгжүүлдэг, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрддөг төрийн байгууллага, албан хаагчдаас эхэлнэ.

Зарчим 2

Гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах



Дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдал, компаниудын нягтрал зэрэг нь хөрөнгө оруулалтад эерэгээр нөлөөлж байхад улс төрийн эрсдэл, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг нь хөрөнгө оруулах сонирхлыг бууруулдаг хүчин зүйлс болдог.

Зарчим 3

Төсвийн сахилгыг хангах,
үндэсний хуримтлалтай болж,
бодит эдийн засаг, инфляцийг
тогтворжуулах



Инфляцийг нам, тогтвортой түвшинд хадгалах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, Төв банкны засаглалыг сайжруулах, валютын ханш макро эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй уян хатан тогтох, төсвийн шинж чанартай хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байх зэрэг бодлогын арга хэмжээ авах.

Зарчим 4

Эдийн засгийн дархлааг хангах
гадаад валютын нөөцийг
хуримтлуулах, өрийн дарамтаас
сэргийлэх



Экспортыг төрөлжүүлж, импортыг орлох үйлдвэржилтийг бий болгосноор гадаад валютын орох урсгалыг тогтмол нэмэгдүүлнэ. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тууштай нэмэгдүүлэх замаар төсөвт ирэх хүүгийн төлбөрийн дарамтыг бууруулах нь гадаад валютын гарах урсгалыг сааруулна.

Зарчим 5

Хүчтэй санхүүгийн салбартай
болох, санхүүгийн зах зээлийг
зохистойгоор либералчлах,
өрсөлдөөнийг дэмжих



Банкны салбарын эрсдэл буурснаар санхүүгийн тогтвортой байдал хангагдаж, хөрөнгийн зах зээлийн хөгжил эрчимжсэнээр бодлогын хүүний шилжих суваг сайжирч, зээлийн зах зээл дээрх өрсөлдөөн нэмэгдэж, зээлийн хүү буурах орчин бүрдэнэ.

Зарчим 6

Аж үйлдвэржилтэд хөтлөх,
гадаад зах зээлд өрсөлдөх
чадвартай компаниудыг бий
болгож, дэмжих



Уул уурхайн салбараас хэт хамаарал багасаж, экспортын орлого нэмэгдсэнээр урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлттэй болно. Мөн олон улсад өрсөлдөх чадвартай компаниудыг дагасан жижиг дунд үйлдвэрлэл хөгжиж, ажилгүйдэл буурснаар эдийн засаг эрүүлжих нөхцөлүүд бүрдэнэ.

Зарчим 7

Дэлхийн болон бүс нутгийн дэд
бүтцийн том хөтөлбөрүүдэд
багтаж орох, газар нутгийн
байршлын давуу талаа ашиглах



Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграцчилал болон эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд нэгдэн орсноор эдийн засгийн цар хүрээг тэлэх, төрөлжүүлэх боломж бүрдэнэ. Мөн дэд бүтцийн хувьд улс дамнасан бүтээн байгуулалтыг хийснээр орон нутгууд тэгш хөгжих боломжтой болно.

Зарчим 8

Байгалийн баялгаа оновчтой
байдлаар эдийн засгийн эргэлтэд
оруулах, баялгийн ерөөлд хүргэх,
хүртээмжтэй өсөлтийг бий болгох



Татварын болон эрх зүйн зөв орчин бүрдүүлж, тээвэр, эрчим хүч зэргээр дэд бүтцээ сайжруулан Монгол Улс эрдэс түүхий эдийнхээ баялаг нөөцийг ирэх хэдэн арван жилийн турш ашиглах баялгийн сан үүсгэн хөгжлийн тогтвортой, урт хугацааны томоохон салбаруудад хөрөнгө оруулалтаа шингээх нь баялгийн ерөөлд хүрэх алхмын эхлэл болно

“УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ”-ИЙН 8 ЗАРЧИМ

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хөрөнгө оруулалтгүйгээр төсөөлөх боломжгүй. Чухамдаа хөрөнгө оруулалтын урсгалыг татраахгүйн тулд бодлогын суурь зарчмаа бид хэрхэн тогтоох ёстой вэ?

Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудахын тулд тогтвортой орчин хэрэгтэй. Тогтвортой орчин гэдэгт юуг анхаарч үзэх нь чухал болохыг доор дурьдав.

- Макро эдийн засгийн тогтвортой орчин (төв банкны бие даасан байдал, бодлогын нийцтэй байдлыг бүрдүүлэх, төсвийн бодлогын хувьд улс төрийн орчноос үл хамаарах)-ыг бүрдүүлэх,
- Төсвийн хөрөнгө оруулалт (дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд) ДНБ-ий тодорхой түвшинд тогтвортой байх,
- Засгийн газрын зүгээс хувийн салбарын хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлдэг бизнесийн таатай орчин (өрсөлдөөн, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, чөлөөтэй байдлыг дэмжсэн татвар, эрх зүйн тогтолцоо)-ыг бүрдүүлэх,
- Иргэдийн эрүүл мэнд, мэдлэг, ур чадварт хөрөнгө оруулалт хийх, мэргэжлийн мэргэшсэн ажиллах хүчнийг бий болгоход анхаарах (хөдөлмөрийн шилжих үйл явцыг чөлөөтэй болгох, дэмжих),
- Шинэ технологийн шилжилтийг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийн технологи, бүтээмжийг байнга өсөн нэмэгдүүлэхэд анхаарах,

- Хөрөнгө оруулалт их хэмжээнээс илүүтэй салбарын хувьд төрөлжүүлэх, ач холбогдолтой салбарт дотоодын хөрөнгө оруулалт түлхүү татах (экспортын салбарын өрсөлдөх чадварыг хамгаалах),
- Дотоодын өндөр хуримтлалыг бий болгоход чиглэсэн хүн амын орлогын түвшин нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын өгөөжтэй тогтолцоог бүрдүүлж нийгмийн хуримтлуулах хандлагад эерэгээр нөлөөлөх, уриалах (санхүүгийн салбарын хөгжил).

Хөгжлийн эдийн засгийн онолын үүднээс буурай хөгжилтэй орны хувьд “бага орлого-бага хуримтлал-бага хөрөнгө оруулалт-бага орлого” гэсэн “чөтгөрийн тойрог”-оос гарахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэж үздэг. Энэхүү хөрөнгө оруулалтын дутагдлыг нөхөх эх үүсвэр нь өөрийн хуримтлал, гадаад эх үүсвэр (зээл, тусламж, хөрөнгө оруулалт) болох бөгөөд нөгөө талаас эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд хөрөнгө оруулалтын нийт хэмжээнээс илүүтэйгээр түүний задаргаа, бүрдлүүд нь илүү чухлаар тавигддаг байна.

Эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудын хувьд нийт хөрөнгө оруулалт нь ДНБ-ий 25 хувиас өндөр байна. Хурдацтай хөгжиж буй Азийн орнуудын хувьд дэд бүтцийн хөрөнгө оруулалт (улсын болон хувийн) ДНБ-ий 5-7 хувь байжээ. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт төсвийн хөрөнгө оруулалт зарим жилүүдэд огцом их

хэмжээтэй байхаас илүүтэй ДНБ-ий тодорхой түвшинд тогтвортой байх нь чухал байна.

Үүнийг хэрхэн бий болгож, хэрэгжүүлэх вэ?

А.Т.Кearney 1000 пүүсийн гүйцэтгэх захирлаас авсан судалгааны үр дүнд хөрөнгө оруулах шийдвэрт хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйлст зах зээлийн хэмжээ, улс төрийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал, ДНБ-ий өсөлт, хууль хяналтын орчин, ашгаа буцаан авах чадвар зэрэг нь хамаардаг гэсэн дүгнэлт хийсэн байна. Эндээс харахад дэд бүтцийн хөгжил, аж үйлдвэржсэн байдал, компаниудын нягтрал зэрэг нь хөрөнгө оруулалтад эерэгээр нөлөөлж байхад улс төрийн эрсдэл, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг нь хөрөнгө оруулах сонирхлыг бууруулдаг хүчин зүйлс болдог байна. Хөрөнгө оруулах шийдвэрт илүү нөлөөлдөг энэ төрлийн хүчин зүйлсд анхаарч, хэрхэн сайжруулах тал дээр бид ажиллах ёстой.

Мөн хөрөнгө оруулалт татахаас илүүтэй урьдач бэлтгэл ажил чухал. Тухайлбал, манай орны хувьд гадаад хөрөнгө оруулалт гадаад валютыг нэмэх биш хасдаг. Учир нь гаднаас зээл нэмж авдаг, мөн гаднаас их хэмжээний импорт хийгээд манай гадаад валютыг гаргадаг. Тиймээс ир ир гэж урихаасаа өмнө гадны хөрөнгө оруулагч хэдий хэмжээний экспорт Монголоос гаргах, үйлдвэрлэлийн орцын хэдэн хувийг дотоодоос авах зэрэг гадаад валютаар олсон ашигт хяналт тавьж, зардлыг нь хязгаарлах арга хэмжээ авч сурах хэрэгтэй. Нөгөө талд ирээдүйд Монголд амин чухал гэж үздэг үйлдвэрийн зарим салбарт хөрөнгө оруулалтыг хязгаарлах ёстой.

Их хэмжээний хөрөнгийн орох урсгал нь үйлдвэрлэлд ямар нэгэн үр бүтээлгүй буюу газар дамлан зарах гэх мэт “ашиг хайх” үйл ажиллагааг өсгөснөөр дотоодын эдийн засгийн бүтцийг өөрчлөн, эдийн засгийн институц-д муугаар нөлөөлдөг тул улс төрийн болоод эдийн засгийн суурь институц сайн бэхэжсэн, тогтвортой байх нь чухлаар тавигддаг байна.

Мөн дотоодын ажиллах хүчний боловсролын түвшинг дээшлүүлэх шаардлага тулгарч буй чухал

асуудлын нэг юм. Учир нь нарийн мэргэшсэн мэргэжлийн ажиллах хүч хангалттай түвшинд бэлтгэгдээгүйгээс гаднаас ажиллах хүч ихээр авах тохиолдол гарч байна. Энэ нь хөрөнгө оруулалтын эерэг байдлыг буюу хөрөнгө оруулалтын ач тусыг хүртэж чадахгүй байна гэсэн үг.

Нөгөө талаас хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө нь дотоодын болон гадаадын компаниудын ашиглаж буй технологийн зөрүүний хэмжээгээр тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, дотоодын компанийн гадаадын технологийг эзэмших чадвараас хамаарна гэсэн үг. Технологийн зөрүү бага байх тусмаа эерэг нөлөө нь илүү байдаг бол зөрүү нь хэт өндөр үед эерэг нөлөөг олж харахад хүндрэлтэй байдаг. Хөрөнгө оруулалтыг тууштай татаж чадсанаар олон улсын туршлагаар дараах эерэг үр дүнгүүд гарна гэж үздэг/ Хүлээгдэж буй үр дүн/:

Эндээс ямар үр дүн хүлээгдэх вэ?

Хөрөнгө оруулалтыг тууштай татаж чадсанаар олон улсын туршлагаар дараах эерэг үр дүнгүүд гарна;

- Орчин үеийн технологийн шилжих процесс явагдана /хуулах, туршлага нэвтрүүлэх гэх мэт/,
- Өрсөлдөөний дарамт өсч, дотоодын аж ахуйн нэгжүүдийн бүтээмж нэмэгдэж, нөөц илүү үр ашигтай зарцуулах замаар нөлөөлнө,
- Шинэ ажилчдад шинэ техник, арга барилд суралцах /Хүмүүн капиталын хөгжүүлэлт/ боломж бүрдэнэ,
- Нийлүүлэгч, түүхий эд бэлтгэгч нарын үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг дэмжинэ /Нийлүүлэгч нарт зууч болох тохиолдол байж болно/,
- Хөрөнгө оруулалтын либерал байдлыг дэмжинэ.

Төрийн бодлого шийдвэрт дээрх асуудлыг харгалзан үзэх нь тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих чухал суурь байх юм.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... /2018.04.26/

Монголбанкнаас сар тутам цаг үеийн асуудлаар зохион байгуулдаг хэвлэлийн бага хурал дөрөвдүгээр сарын 26-ны өдөр болж, мөнгө санхүүгийн статистик мэдүүлүүд болон бусад холбогдох асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өглөө.

МҮОНТ: Өрийн хэмжээ буурсан гэж байна. Гэхдээ өрийн хэмжээ Засгийн газрын өрийн таазтай харьцуулахад хэдэн хувьтай байна вэ. Удахгүй төлөгдөх их өрийг шийдэхэд ямар менежмент хийх ёстой вэ?

Мөнгөний бодлогын газар /МБГ/-ын захирал Б.Баярдаваа:

Та бүхний мэдэж байгаачлан 2016 оны төгсгөлд Засгийн газрын нийт өрийн хэмжээ ДНБ-ий 90 гаруй хувьтай тэнцэж байсан. Одоо бидэнд байгаа мэдээллээр Засгийн газрын өрийн хэмжээ 2017 онд ДНБ-ий 78 хувьд хүрч, үлэмж хэмжээгээр буураад байна. Энэ нь нэг талаас төсвийн алдагдлын хэмжээ буурч, татварын орлого бүрдүүлэлт өсч, эдийн засаг сэргэж байгаатай холбоотой. Нөгөө талаас төсвийн зарлага хяналттай байна. ОУВС-тай тохирсны дагуу төсвийн орлого, зарлага, алдагдлын параметр, тоон үзүүлэлтүүд хангагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор өрийн хэмжээ буурч байна. Бидний зүгээс 2018 онд өрийн хэмжээ ДНБ-ий 70 орчим хувьд буурах төсөөлөлтэй байна. Мөн 2019 оноос 66-67 хувь руу буурах болов уу гэж харж байгаа. Анх Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдаж байх үед өрийн хэмжээ ДНБ-ий 40-45 хувь байхаар тогтоож байсан. Гэвч төсвийн орлого буурч, зардал нэмэгдээд, төсвийн хэт их тэлсэн бодлогууд явагдаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа өөрчлөлт оруулж, өрийн хэмжээг нэмэгдүүлсээр нэг мэдэхэд л өрийн хэмжээ маань ДНБ-ий 90 орчим хувьтай тэнцчихсэн. Одоо эдийн засаг сайжрахын хэрээр өрийн хэмжээ бага багаар буурч, тогтворжиж байна. Цаашдаа 2020-2021 оноос өрийн хэмжээ ДНБ-ий 50 орчим хувь

руу орж ирэх болов уу. Тэгэхээр цаашдаа төсөвт ирж байгаа дарамт, санхүүжилтийн хүндрэлүүд аажмаар буурна гэсэн үг. 2021-2022 онд өрөө хэрхэн төлөх вэ гэдэг асуултад хариулахад Засгийн газрын зүгээс тэр хүртэлх хугацаанд өрийг төлөх санхүүгийн чадавхиа бий болгосон байх, төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний нөөцийг хуримтлуулсан байх ёстой. Хоёрдугаарт, энэ өр төгрөгөөр биш ам.доллараар төлөгдөнө. Тэгэхээр энэхүү нөөцийг долларын хэмжээнд бий болгосон байх ёстой. Долларын санхүүгийн чадавхи нь гадаад валютын албан нөөцөөр илэрхийлэгдэнэ. Одоогоор ГВАН 3 тэрбум ам.долларт хүрсэн. Гэхдээ энэ нь өрийг төлөхөд хангалттай биш гэж Монголбанк үзэж байгаа. Тэгэхээр цаашид өрийн эргэн төлөлтөд бэлдэхийн тулд валютын нөөцийг нэмэгдүүлэх шаардлага бий. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тунхаг бичигт Монгол Улсын гадаад валютын нөөцийн хэмжээ улс орны нэг жилийн импортын хэрэгцээг хангахуйц түвшинд байх ёстой гэж тусгасан байдаг. Одоо байгаа импортын хэмжээ жилдээ 4.3 орчим тэрбум ам.доллар байдаг. Цаашид эдийн засаг сэргэхийн хэрээр импортын хэмжээ нэмэгдэнэ. Тэгэхээр энэ үзэл баримтлалынхаа түвшинд хүрэхийн тулд валютын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

"Үндэсний шуудан" сонин: Арилжааны банкуудын чанаргүй зээлийг Монголбанк худалдан авах тухай асуудал яригдаж байсан. Энэ талаар тодруулахгүй юу?

Хяналт, шалгалтын газрын захирал Н.Батсайхан:

Монголбанк банкуудын чанаргүй зээлийг худалдаж авах тухай шийдвэр огт гараагүй бөгөөд энэ тухай

асуудал ч мөн яригдаагүй. Харин Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл дээр Монголбанк Засгийн газартай хамтран ажиллаж байгаа. Ойрын хугацаанд УИХ-д өргөн барина.

ТВ5: Мөнгөний бодлогын хүрээнд цаашид эдийн засгийг тэлэх бодлого явагдах уу?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

2016 оны наймдугаар сард бодлогын хүүг өсгөснөөс хойш Монголбанкны бодлогын арга хэмжээнүүдийг харвал эдийн засгийн хүндрэл багасахын хэрээр эдийн засаг руу нийлүүлэх мөнгөний нийлүүлэлтийг бага багаар нэмэгдүүлж, тэлэх бодлого хэрэгжүүлсэн байгаа. 2016 оны наймдугаар сард бий болсон хүндрэлийг эргэн санавал тэр үед эдийн засгийг өсгөх тухай асуудал огт байгаагүй. Өөрөөр хэлбэл, эдийн засаг өсөхөөсөө илүү эдийн засаг нь өөрөө унтарчих гээд байсан. Төсөв, гадаад төлбөр тооцоо талаасаа маш хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. Ийм нөхцөлд эдийн засаг гэдэг машинаа яаж унтраахгүй байх вэ гэдэг дээр анхаарал хандуулж, бодлогын арга хэмжээнүүд авсан. Зөвхөн мөнгөний бодлогоос гадна төлбөрийн тэнцлийн хүндрэлийг даван туулах, хугацаа нь тулсан өрийг яаж шийдвэрлэх, орлогоосоо хэт их давсан төсвийн зардлыг хэрхэн санхүүжүүлж, төсвийг тогтворжуулах вэ гэх зэрэг маш олон хүндрэлтэй нөхцөл байдал бий болсон. Түүнчлэн хувийн сектор талдаа хувийн сектор санхүүгийн сектороос санхүүжилт авах боломж маш хязгаарлагдмал болж, арилжааны банкуудын зээлийн эрсдэлийн шалгуурыг давах аж ахуйн нэгжүүд ховордсон. Арилжааны банкуудын зээл олгох санхүүгийн чадавхи ч бас хүндрэлтэй болсон байсан. Сүүлийн нэг жил гаруй хугацаанд энэ хүндрэлүүд бага багаар илааршиж байна. Засгийн газрын санхүүжилтийн дарамт шийдэгдсэн. Гадаад төлбөр тооцооны хүндрэл илааршиж, тулсан байсан өрийн эргэн төлөлтийг хойшлуулж, амьсгаа авах хугацаатай боллоо. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсч, дагаад экспорт нэмэгдэж байна. Бодлогын оновчтой арга хэмжээнүүдийн үр дүнд хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байна. Үүнтэй холбоотойгоор Оюутолгой гэлтгүй бусад салбар дээр гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байна. Өнгөрсөн онд л гэхэд 400 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт Оюутолгойгоос гадна Монгол Улсад орж ирлээ. Мөн ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд 700 орчим сая ам.доллар орж ирсэн нь

эдийн засагт дэмжлэг үзүүлж байна. Тэгэхээр гадаад эдийн засгийн төлөв байдал богино хугацаандаа сайжирч байна. Яагаад богино хугацаанд сайжирч байна вэ гэхээр цаашдаа гадаад төлбөрийн тэнцэл, санхүүжилтийн дарамтыг тогтворжуулах зорилт хэвээр байгаа. Бид гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх ёстой. Монгол Улсын Засгийн газар энэ асуудлыг бодлогын томоохон зорилтоо болгосон гэж ойлгож байгаа. Энэ утгаараа эдийн засгийг тэтгэх бодлого 2017 оноос хийгдээд эхэлсэн. Гэхдээ эдийн засгийг тэтгэх гэхээсээ илүү эдийн засгийн өсөлтөө дунд болон урт хугацаандаа хэрхэн хангах вэ гэдэг асуудал илүү чухал. Тэгэхээр эдийн засгийг тэтгэх, урамшуулах бодлого нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах том зорилгынхоо дор явах ёстой. Богино хугацаанд эдийн засгаа өсгөсөн ч урт хугацаанд томоохон дарамт, хүндрэл авчрах бодлого байж болохгүй.

Монголын үнэн: Ипотекийн зээлийн олголт ямар түвшинд явж байна вэ. Монголбанк ямар оролцоотой байгаа вэ?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин:

Энэ жил Монголбанкнаас олгож байгаа санхүүжилтийн жилд олгож буй хэмжээ 220 орчим тэрбум төгрөг бол Засгийн газраас 120 орчим тэрбум төгрөг. Ингээд нийт 340 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт энэ онд хийгдэнэ. Оны эхний дөрвөн сарын байдлаар санхүүжилт хуваарийнхаа дагуу явагдаж байна. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Монголбанк, Барилга, хот байгуулалтын яамны зүгээс цаашид ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрхэн тогтвортой, дарамт багатайгаар үргэлжлүүлэх вэ гэдэг схемийг гаргах ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгийн түвшинд ипотекийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх хэд хэдэн хувилбар яригдаад, эхний хувилбар Засгийн газраар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Цаашдаа ипотекийн хөтөлбөр Засгийн газрын манлайлал дор, Засгийн газрын төсвийн нэгдмэл байдлыг хангах хүрээнд хэрэгжинэ. Тийм учраас одоогоор Засгийн газрын хуралдаанаар батлагдах шатандаа явж байгаа.

ТВ8: Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги боловсруулах ажил ямар шатандаа явж байна вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

-Зээлийн хүүг бууруулах асуудал Эдийн засгийн байнгын хороо, Их хурал дээр яригдаж байгаа. Энэ хүрээнд Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд Зээлийн хүүг бууруулах стратегийг боловсруулах үүргийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд өгөхөөр тусгагдсан. Энэ хүрээнд Монголбанкны түвшинд Зээлийн хүүг бууруулах үндэсний стратегийн төслийг боловсруулж, олон нийтэд танилцуулсан байгаа. Дараагийн шатанд энэ бодлогын баримт бичгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Өөрөөр хэлбэл, уг баримт бичигт Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны саналыг авч, тусгасны дараа Их хуралд хүргэгдэнэ.



Блүүмбэрг ТВ: Саяхан Азийн хөгжлийн банкнаас эдийн засгийн өсөлтийн төсөөллийг гаргасан. Гэвч энэ төсөөлөл Монголбанк болон Засгийн газрын төсөөллөөс зөрүүтэй байгаа. Ер нь аливаа төсөөлөл, тооцоо, судалгааны хувьд олон улсын

байгууллагуудын хэлж байгаа тоо Монголбанк, Засгийн газрын төвшинд танилцуулсан тооноос зөрдөг. Энэ ямар учир шалтгаантай юм бол?


МБГ-ын захирал Б.Баярдаваа:

Төсөөллийн хувьд эдийн засгийн байгууллагуудын өөр өөр таамаглалт нөхцөлүүдээс хамаарч байгаа. Өөрөөр хэлбэл, Засгийн газар төсвийн алдагдлаа гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх үү, дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх үү гэдгийг АХБ хэрхэн харж байна вэ гэдгээс шалтгаална. Үүнтэй адилхан Монголбанк, Засгийн газар, ОУВС-ийн зүгээс энэ асуудлыг хэрхэн харж байна вэ гэдгийг өөр, өөрөөр харж байгаа. Түүнчлэн Монгол Улсын төлбөрийн тэнцэл ямар түвшинд байх вэ гэдгийг тухайн байгууллагууд өөр өөрөөр харж, тайлбарлаж байгаа. Тухайлбал, экспортын үнэ ямар байх, импортын хэмжээ ямар байх, хөрөнгө оруулалт хэр их байх гэх зэрэг асуудал. Тэгэхээр төсөөлөл заавал нэг түвшинд адилхан байх албагүй.


2018 оны гуравдугаар сарын эдийн засгийн статистик тойм



Зураг 2.3. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив




Зураг 2.4. Дотоод цэвэр активын бүтэц, тэрбум ₮



Зураг 2.5. Зээл, зээлийн чанар




Зураг 2.6. Зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбарын ангиллаар




- Нийт зээл 14.0 их наяд ₮ (₮ зээл 11.0 их наяд ₮, \$ зээл 3.0 их наяд ₮)
- Хэвийн зээл өмнөх сараас 314.3 тэрбум ₮ буюу 2.3%-иар нэмэгдсэн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 57.0 тэрбум ₮ буюу 5.8%-иар буурсан.
- Чанаргүй зээл өмнөх сараас 34.3 тэрбум ₮ буюу 2.7%-иар буурсан байна.

Зураг 2.7. Зээлийн ЖДХүү




- Тухайн сард олгосон Зээлийн хүү ₮ 19.1%, \$ 11.3%
- Үлдэгдлээрх зээлийн хүү ₮ 18.1%, \$ 11.0%

Зураг 2.8. Хадгаламжийн ЖДХүү



- Тухайн сард олгосон хадгаламжийн хүү ₮ 11.4%, \$ 5.0%
- Үлдэгдлээрх хадгаламжийн хүү ₮ 12.8%, \$ 5.2%


Зураг 2.9. Ипотекийн зээлийн үлдэгдэл



Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.3 хувиар өсчээ.


Ипотекийн зээл 4.3 их наяд ₮, зээлдэгчдийн тоо 93099

Зураг 2.10. Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь




95.7% хэвийн, 2.4% хугацаа хэтэрсэн, 1.9% чанаргүй зээл байна.

Зураг 2.11. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон дундаж зээл




Нэг зээлдэгчид дундаж 78.3 сая төгрөг ногдож байна.

Зураг 2.12. Барьцаа хөрөнгийн талбай хэмжээгээр




Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.7% буюу 3856.3 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Зураг 2.13. Барьцаа хөрөнгийн ашиглалтад орсон оноор



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 49.4% буюу 2.5 их наяд төгрөгөөр 2011-2015 онд ашиглалтад орсон орон сууц худалдан авчээ.

Зураг 2.14. Зээлдэгчийн орлого



Нийт зээлдэгчдийн тоо 93099 байгаагийн 69.3% нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой байна.



ТӨВ БАНК ЮУ ХИЙДЭГ ВЭ ?



Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;

- 1.Монголбанк Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.
- 2.Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх, хуурамч мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргахыг хориглоно



Мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогын зорилт, төгрөгийн ханш, санхүүгийн зах зээлд нөлөөлж болох хүчин зүйлсийн талаарх төсөөллийг боловсруулна.



Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;

Төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэх, Засгийн газраас гаргасан үнэт цаасыг бусад этгээдэд зуучлан борлуулна.



Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих

Банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;

- 1.Монголбанк Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавина.
- 2.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд холбогдсон харилцааг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар зохицуулна.



Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;

Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангах үүрэгтэй.



Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаална.



Макро зохистой бодлого хэрэгжүүлэх

Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж

НАЙМАН ХУВИЙН ИНФЛЯЦИД ЗОРЬСОН НЬ ИНФЛЯЦИЙН ДУНДЖИЙГ АЛГУУР БУУРУУЛАХ АЛХАМ



Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн инфляцийн богино хугацааны төсөөлөл хариуцсан эдийн засагч Ж.Энхбаяртай "Төв банк ба үнийн тогтвортой байдал" сэдвийн хүрээнд ярилцлаа.

Юуны өмнө уншигчдад маань өөрийн эрхлэдэг ажлынхаа талаар сонирхуулна уу?

Улирал тутам хуралддаг Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэр гаргалтад шаардлагатай тооцоо, шинжилгээ хийж, бодлогын санал боловсруулах нь Мөнгөний бодлогын газрын мэргэжилтнүүдийн гол ажил байдаг. Миний ажиллаж буй Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтэс нь макро эдийн засгийн гадаад болон дотоод орчны ойрын хугацааны төсөөлөл, шинжилгээ хийхэд төвлөрдөг. Хамт ажилладаг эдийн засагч нар маань дотоодын нийт бүтээгдэхүүн, хөдөлмөрийн зах зээл, төлбөрийн тэнцэл, олон улсын эдийн засаг — гадаад орчин, түүхий эдийн үнэ гэх мэт өөр өөрийн хариуцсан чиглэлээр дата цуглуулж, шинжилгээ төсөөллөө боловсруулдаг. Харин миний хувьд инфляцийн богино хугацааны төсөөллийн тооцоолол дээр ажилладаг. Үүний хүрээнд эдийн засагт сүүлийн үед өрнөсөн үйл явдлын статистик мэдээг цуглуулан шинжилгээ хийнэ. Мөн ойрын хугацаанд учирч болзошгүй

өөрчлөлтүүдийн чанарын мэдээлэлд үндэслэн загвараар тооцоход хүндрэлтэй үр дүнг гарган авч үр дүндээ оруулдаг. Бидний боловсруулсан үр дүнг цааш нь дунд, урт хугацааны төсөөлөлд орц болгон ашиглаж, түүн дээр үндэслээд мөнгөний бодлогын саналын хувилбарууд боловсруулагддаг. Мөнгөний бодлогын хорооны гишүүд бодлогын хүүг тогтоох хурлын үеэр тэрхүү саналыг хэлэлцээд, шийдвэрээ гаргадаг.

Өөрийн тань хувьд инфляцийн судалгаа, шинжилгээгээр мэргэшсэн эдийн засагчийн хувьд инфляци эдийн засагт ямар үүрэгтэй болох талаар тайлбарлаж өгнө үү?

Эдийн засаг дахь ерөнхий үнийн түвшний өсөлтийг бид инфляци гэж нэрлэдэг. Зах зээл дээр зарим бараа хямдарч, зарим нь үнэтэй болдог ч ерөнхий чиг хандлага нь хаашаа чиглэж байгааг харуулдаг үзүүлэлт гэсэн үг. Хэрэв цалин орлого тогтмол үед бидний хамгийн их худалдан авдаг бараа үйлчилгээнүүдийн үнэ хурдтай өсөөд эхэлбэл худалдан авах чадварт сөрөг байх болно. Энэ утгаараа инфляци иргэдийн

амьжиргаанд маш чухал нөлөөтэй учраас үнийн түвшний өсөлт нам бөгөөд тогтвортой байх шаардлагатай байдаг. Харин бизнес эрхлэгчийн өнцгөөс харвал, бараа үйлчилгээний үнэ цаашид хэр өсөлттэй байх нь бизнес төлөвлөгөөнд нь мэдээж нөлөөтэй. Ажилтнуудын тоо, хөрөнгө оруулалтын зардал, үйлдвэрлэлийн хэмжээгээ тодорхойлоход ирээдүйд бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь үнэ хэрхэн өөрчлөгдөх вэ гэдэг чухал байх болно. Иймд, хэрэв дефляци буюу үнэ буурах үзэгдэл удаан үргэлжилвэл бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх сонирхол буурах эрсдэлтэй. Түүнчлэн, инфляци мөнгөний үнэ цэнэд шууд нөлөөтэй учир санхүүгий систем, эдийн засаг тогтвортой байх нэг чухал тулгуур болдог. Хэрэв үнэ өсч, мөнгөний үнэ цэнэ огцом буураад эхэлбэл хүмүүс санхүүгийн байгууллагад мөнгөө хадгалуулахгүй, улмаар эдийн засагт санхүүгийн зуучлал саарч, эдийн засаг удаашрах, тогтворгүй болох эрсдэлтэй.

Эдийн засагт үнэ тогтвортой байх нь иргэдийн амьжиргаа, бизнес эрхлэгчдийн

үйл ажиллагаа, банк санхүүгийн системийн тогтвортой байдалд ч чухал нөлөөтэй байх нь. Тэгвэл манай орны инфляцийн гол онцлог нь юу вэ?

Үндсэндээ 3 онцлогийг нэрлэж болно. Нэгт, ирээдүйн инфляцийг тодорхойлдог чухал хүчин зүйл болох зах зээлд оролцогчдын инфляцийн хүлээлт тогтворжоогүй байдал нь нэг гол онцлог юм. Инфляци нэг талаас эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн зэрэгцээ, нөгөө талаас тухайн улс орныхоо онцлогийг илэрхийлэх үзүүлэлт болдог. Эдийн засгийн үйлдвэрлэх чадвар, импортын бүтэц, зах зээлд оролцогчдын сэтгэлзүй, төсвийн бодлого, хөрөнгө оруулалтын орчин, экспортын орлого, валютын ханш, эдийн засгийн идэвхжил гээд олон зүйлийн тусгал болдог гэсэн үг. Манай орны хувьд бусад макро үзүүлэлтүүд тогтвортой бус байсан тул инфляци өндөр бөгөөд савлагаатай явж ирсэн. Үүнийг дагаад зах зээл дээрх инфляцийн хүлээлт харьцангуй тогтвортой бус байдаг онцлогтой. Жишээ нь, макро орчин нь тогтвортой хөгжсөн улс орнуудад 10 жилийн дараах инфляцийн хүлээлт ч нэлээд тогтмол болчихсон, барагтай бол өөрчлөгддөггүй онцлогтой байдаг. Хоёрт, манай хэрэглээний сагсны 40% орчим нь импортын бараа тул дотоодын үнийн түвшин валютын ханшнаас ихээхэн хамааралтай. Тэгэхээр инфляци маань ханшийг тодорхойлох суурь хүчин зүйл болох дотоодын үйлдвэрлэх чадвар, эдийн засгийн төрөлжилт,

аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар, экспорт хийж валют олох чадвар зэргээс өндөр хамааралтай гэсэн үг. Гуравт, хүнсний бүтээгдэхүүн, тэр дундаа мах, ногоо зэрэг цөөн төрлийн бүтээгдэхүүн үнэ улирлын онцлогоор өндөр хэлбэлзэж, инфляцид хүчтэй нөлөө үзүүлдэг. Энэ нь манай орны өрхийн амьжиргааны түвшин, хэрэглээний онцлогтой холбоотой. Жишээ нь, нэг хүнд ногдох ДНБ, өрхийн орлогын түвшнээр манайхтай ойролцоо өөр улсад инфляцид үзүүлэх махны үнийн нөлөө арай өөр байх болов уу.

Тэгвэл инфляцийг ер нь яаж хэмждэг вэ, ирээдүйн таамаглалыг тооцоолоход юунд анхаарах шаардлагатай байдаг вэ?

Инфляцийг бид Үндэсний статистикийн хорооноос тооцож гаргадаг хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмждэг. Төв банк үнийн түвшний талаар ярихдаа “ХҮИ-ээр илэрхийлсэн инфляци”-ийг 8%-д тогтворжуулна гэдэг нь үүнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, манай улсын хэрэглээний сагс буюу хэрэглэгчдийн хамгийн өргөн хэрэглэдэг 344 бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний дундаж үнийн өөрчлөлт эдийн засагт маань үнийн түвшин хэр тогтвортой байгааг илэрхийлэх хэмжүүр болдог гэсэн үг. Мөнгөний бодлого тодорхой цаг хугацааны хоцрогдолтойгоор эдийн засгийн эрэлт, идэвхжил, улмаар үнэд нөлөөлдөг тул инфляцийн

одоогийн гүйцэтгэлээс гадна цаашдын төсөөлөл чухал байдаг. Цаашдын таамаглалыг хийхэд бусад макро хүчин зүйлсийн нөлөөг загварт оруулан тооцохоос гадна, хэрэглээний сагсан дахь бараа, үйлчилгээ тус бүрийн үнийн хэлбэлзэл, улирлын хандлагыг судалдаг. Ялангуяа сагсанд өндөр жинтэй, инфляцид хүчтэй нөлөө үзүүлдэг бүтээгдэхүүний үнэ хэрхэн хэлбэлзэх нь маш чухал юм. Жишээ нь, өвөлжилт хүндрэх эсвэл зуны улиралд хур багатай байсан зэргээс үүдэн мах, хүнсний ногооны үнэ огцом өөрчлөгдөн, улмаар инфляци хэлбэлзэх үе бий. Иймд зарим тохиолдолд хур тунадасны хэмжээг судалж тооцоололдоо ашиглах үе хүртэл бий. Мэдээж ийм нөлөөллийг бүрэн тооцох төвөгтэй учир өнгөрсөн онуудад ургац алдаж байсан, малын хорогдол их байсан үеүдэд эдгээр бүтээгдэхүүний үнэ хэрхэн хөдөлж байсныг давхар судалж, эцсийн үр дүнг гаргаж авахдаа ашигладаг.

Илүү бодит төсөөлөл хийхийн тулд хэрхэн ажилладаг вэ?

- Нэн тэргүүнд тооцоонд ашиглаж буй мэдээллийн чанар маш чухал. Иймд гадаад болон дотоод эдийн засгийн үзүүлэлтүүдийн сүүлийн үеийн статистик, тоон мэдээг холбогдох байгууллагуудаас тухайн сэдэв, сектор хариуцсан эдийн засагчдаараа дамжуулаад авдаг. Тооцоолол хийдэг аргачлалын хувьд, одоогийн байдлаар инфляцийн богино хугацааны

төсөөллийг нэг хувьсагчийн загвар ашиглан үнэлж байна. Ингэхдээ бараа, бүтээгдэхүүний үнийг тухайн барааны үнийн өмнөх жилүүдийн хандлага, дундаж өөрчлөлтөд тулгуурлан тооцдог. Цаашид тооцооллоо сайжруулах зорилгоор бусад олон хувьсагчийн загваруудыг хөгжүүлж инфляцийн богино хугацааны төсөөлөлд ашиглаж эхлээд байна. Өмнө хэлсэнчлэн зарим чанарын мэдээллийг нэмж цуглуулаад төсөөлөлдөө тусгах тохиолдол чухал байдаг. Тухайлбал, сүүлийн хэдэн төсөөллийг хийхэд шатахууны үнэ өөрчлөгдөх эсэх, зарим төрлийн татвар нэмэгдэх эсэх нь нэлээд чухал нөлөөтэй байсан. Эдгээр өөрчлөлтийн талаарх баттай эх сурвалжийн мэдээн дээр үндэслэн зарим бараа үйлчилгээний үнэ болон инфляцид үзүүлэх шууд болон дам нөлөөллийг тооцож, богино хугацааны төсөөлөлдөө оруулснаар прогноз алдаа багатай, илүү бодит болно гэсэн үг юм.

Монголбанк инфляцийн түвшинг 8% орчимд тогтворжуулах зорилттой байгаа. Яагаад заавал 8% бэ гэдэг дээр судлаачийн хувьд ямар тайлбарыг өгөх вэ?

- Сүүлийн 20 гаруй жилийн түүхэн статистикаас харахад манай улсад инфляци харьцангуй өндөр бөгөөд савалгаа ихтэй байсан. Үнийн өсөлт 90-ээд оны эхээр 300% давж байсан үеэс хойш инфляци алгуур буурсаар байгаа ч, сүүлийн 10 жилийн дунджаар Улаанбаатар

хотын инфляци 9-10% орчим байв. Зарим жилүүдэд үүнээс өндөр, зарим жилүүдэд үүнээс бага байдаг ч тухайн үеийн эдийн засаг, бизнесийн мөчлөг, бодлогын нөлөө болон бусад эрэлт, нийлүүлэлтийн гаралтай олон хүчин зүйлээс хамаарч байсан гэсэн үг. Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгасан 8% гэдэг инфляцийн зорилтот түвшин бол олон жилийн дунджаар 2 оронтой тоогоор хэмжигдэж, өндөр савлагаатай байсан инфляцийн дунджийг алгуур бууруулах шат дараатай алхмын нэг хэсэг гэж ойлгох нь зүйтэй байх. Дунд хугацаанд инфляци энэхүү зорилтот түвшинд хадгалагдсанаар эдийн засаг тогтворжиж, хүлээлт тогтворжих суурь нь болно. Цаашид дараа дараагийн алхмыг хийх, үнийн тогтвортой байдлыг тууштай хангах илүү таатай нөхцөл бүрэлдэх болов уу.

Аливаа төв банкуудын мөнгөний бодлогын гол зорилго нь үнийн тогтвортой байдал буюу инфляци байдаг. Инфляцийн шинжилгээ, төсөөлөл хийх ажлыг мөнгөний бодлого боловсруулах өнцгөөс харахад ямар гол онцлогтой байдаг вэ?

Хэд хэдэн зүйлийг нэрлэж болно. Юуны өмнө инфляцийг бүрдүүлж буй хүчин зүйлс нь эрэлтийн гаралтай юу, эсвэл нийлүүлэлтийн гаралтай юу гэдгийг салгаж харах нь чухал байдаг. Учир нь бодлогын хүү

г.м. мөнгөний бодлогын хэрэгсэл нь валютын ханш, зээлийн өсөлт, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг сувгуудаар дамжаад эцсийн дүндээ хэрэглээнд, эдийн засагт эрэлт талаас нь нөлөөлдөг. Харин цаг агаарын нөлөө, татвар, зохицуулалттай үнийн өөрчлөлт г.м. нийлүүлэлт талаас шалтгаалсан инфляцид мөнгөний бодлогоор нөлөөлж удирдана гэдэг төвөгтэй. Үүний дараагаар суурь инфляци буюу ерөнхий инфляциас үнийн савлагаа ихтэй бараа бүтээгдэхүүний нөлөөг хассан үзүүлэлтийг давхар ажиглаж байх нь эдийн засагт үнийн түвшний өөрчлөлт аль чиглэлд явж буйг дүгнэхэд чухал байдаг. Жишээ нь, нэг намар ургац бага хурааснаар хүнсний ногооны үнэ нэмэгдэх эсвэл өвөл хүйтэрч түлшний үнэ нэмэгдэж, инфляци өсөх үед эдийн засагт халалт үүслээ гэж дүгнэх нь учир дутагдалтай. Энэ үед суурь инфляци, түүний цаашдын тренд нь илүү бодит дүгнэлт хийх боломжийг олгодог. Түүнчлэн, эдийн засагт оролцогчдын хүлээлт маш чухал. Жишээ нь, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ эсвэл валютын ханшийн өөрчлөлт нь дотоодын бараа үйлчилгээний үнэд мэдээж нөлөөтэй. Харин бензиний үнэ, валютын ханшаас болж бизнес эрхлэгчид үнээ хэр их өөрчлөх вэ гэдэг шийдвэр нь аль цаг үед, ямар нөхцөл байдалд байгаагаас шалтгаалаад тухайн үеийн сэтгэлзүйтэй шууд холбоотой байдаг.

Сонирхолтой яриа өрнүүлсэнд баярлалаа.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНК



Баян-Өлгий аймагт анх байгуулагдсан 3 албан байгууллагын нэг нь Банкны хэлтэс буюу одоогийн Монголбанкны салбар юм. Тус салбар нь анх Баян-Өлгий аймаг үүсэн байгуулагдснаас /1940.08.20/ 3 сарын дараа буюу 1940 оны 11 дүгээр сарын 18-нд Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкны Ерөнхий хорооны шийдвэрээр Ховд аймгийн банкнаас томилогдсон 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагджээ.

Баян-Өлгий аймаг дөнгөж байгуулагдаж байсан үе тул Банкны хэлтэс нь тэр үеийн албан байгууллагын нэгэн адил үйл ажиллагаагаа Ховд голын хөвөөн дээр эсгий гэрт явуулж байсан ч мэргэжлийн боловсон хүчнээр ихээхэн дутагдалтай байжээ. Банкны хэлтсийн анхны даргаар Төв аймгийн харьяат Б.Дорж, ерөнхий нягтлан бодогчоор н.Цэвэлмаа, данс хөтлөгч, кассын нярваар Ховд аймгийн харьяат Б.Лхамсүрэн, А.Гонгор нар ажиллаж байв.

Банк анх байгуулагдсан 1940 онд балансын нийт гүйлгээ 7,803.4 мян.төг, кассын орлого 410.0 мян.төг, зарлага 409.0 мян.төг хадгаламжийн үлдэгдэл 10.0 мян. төг, олгосон зээл 2,026.9 мян.төг, Улсын байгууллагын хөрөнгө оруулалт 2,0 мянган төгрөгт хүрсэн байв.

Харин ЗХУ-тай экспорт, импортын бараа гүйлгээ хийдэг тус аймгийн Цагааннуур дахь салбар хэлтэс аймаг байгуулагдахаас өмнө 1932 онд байгуулагджээ. Улсын банкны Цагааннуур дахь салбар хэлтэс нь аймаг байгуулагдахаас 8 жилийн өмнө 1932 онд байгуулагдсан түүхтэй.

Харилцагчдын тоо, үйлчилгээний хүрээ тэлж, гүйлгээний хэмжээ өссөнөөр 1963 онд Дэлүүн, Цэнгэл сум, Цагааннуурын дамжлага баазын дэргэд 3 салбар хэлтэс, 1964 оноос Булган, Толбо, Алтай, Буянт, Баяннуур, Алтанцөгц, Улаанхус, Сагсай, Бугат, Ногооннуур сум, Хотгорын уурхайд тооцооны касс байгуулагдан ажиллаж, банкны үйлчилгээг аймгийн

нийт хөдөлмөрчдөд ойртуулан, орон тоо, зохион байгуулалт, боловсон хүчин, материаллаг баазын хувьд бэхэжжээ. Банкны үйлчилгээг ойртуулан тооцооны касс байгуулагдсаныг сум орон нутгийн удирдлага, иргэд баяр талархалтай хүлээн авч, тухайн сумын нэгдэл, сангийн аж ахуй, худалдаа бэлтгэлийн ангиуд ажиллах орон байр, түлээ түлшээр үнэ төлбөргүй хангаж, тухайн суманд байгаа хамгийн үнэнч шударга, нэр хүндтэй хүмүүсээ санал болгон тооцооны касс ажиллуулж байсан нь зөрчил дутагдал гаргахгүй байх үндэс нь болсон юм.

Энэ хугацаанд 1971 онд банкны зориулалтын 2 давхар конторын барилгыг ашиглалтанд оруулж, бүх салбар нэгжүүдийг орон байр, мөнгө хадгалах бат бэх авдар саваар ханган, бүртгэлийн ажлыг механикжуулж, тухайн үеийн дэвшилтэд технологи болох "Аскота-170", "Аскота-177" машинаар гүйцэтгэдэг болжээ. Нийт ажиллагсдын 70-аад хувь нь дээд, тусгай дунд боловсролтой, банкны курс төгссөн боловсон хүчнээр хангагдаж, ажлын тоо, чанарын хувьд томоохон өөрчлөлт гарчээ. Улмаар 1979 оны 1 дүгээр сарын 1-нээс "Банкны контор" болон өргөжиж, бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхэжсэн байна. 1990 оноос өмнө банкны хэлтэс, контор, түүний харьяа салбар, тооцооны кассууд улс ардын аж ахуйн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, бэлэн мөнгө, зээл, тооцоо, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр үйлчилж, тэдний санхүүгийн үйл ажиллагаанд нь төгрөгөөр хяналт тавих, улирал, жилийн тайлан балансад эдийн засгийн дүн шинжилгээ, судалгаа хийх, ашигтай ажиллах, эргэлтийн хөрөнгийг бүрэн бүтэн байлгаж, банкны зээлийг зориулалтаар нь зөв ашигласан үйлдвэр, аж ахуйн газруудад зээлийн хүүг хөнгөлж урамшуулал үзүүлэх, хөдөлмөрчдийн гар дээр хуримтлагдсан сул чөлөөтэй мөнгийг хадгаламжинд хуримтлуулж, зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг үүргийг гүйцэтгэж байлаа.



Зүүн гар талаас: Монголбанкны салбарын захирал Ханатын Серёжа, Хянан шалгагч Улсын байцаагч Рахатын Тилеужан, Онтуганы Айым, Нягтлан бодогч Батсүхийн Амарбаясгалан, Нярав Алейн Дауренбек, Жолооч Равсалын Пүрэвсүрэн, Үйлчлэгч Хадалханы Ваня

Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжин орж, 1991 онд “Банкны тухай хууль” батлагдсанаар Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар аймгууд дахь банкны конторыг татан буулгаж, түүний суурин дээр Монголбанкны салбар болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Тус банкиг үүсгэн бэхжүүлэхэд даргаар нь ажиллаж байсан Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Д.Женисхан (энэ хүн урьд нь аймгийн МАХН-ын хороо, АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дарга байсан), Т.Төндбай, Р.Хавалхан, Б.Пунцагдорж, Монгол Улсын Гавьяат эдийн засагч М.Зейнелхан, зээлийн байцаагч Т.Рэгзэн, Цагааннуурын салбарын эрхлэгч байсан М.Жампейс зэрэг хүмүүс үнэтэй хувь нэмэр оруулжээ.

ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭРЭГЖИЛТ



Аймгийн ЗДТГ, БСУГ, сумдын удирдлагууд, ТББ-тай хамтран иргэд, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, малчдад Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал цаашдын чиг хандлага, Монголбанкаас баримталж буй мөнгөний бодлого, банкны салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга хийж, “Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ”, “Монгол алт”, “Санхүүгийн боловсрол”, “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяны хүрээнд сургалтууд зохион байгуулан ажиллаж байна.

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Тус аймагт Хаан, Хас, Капитрон, Голомт, Төрийн, Капитал банкны 6 салбар 34 тооцооны төвд 246 ажилтан ажиллаж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаарх

арилжааны банкуудын зээлийн үлдэгдэл 132.6 тэрбум төгрөг бол, харилцах, хадгаламжийн дансаар 83.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээ. Аймгийн инфляци 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 5.9 хувтай гарсан байна. Арилжааны банкууд 2017 онд 51.3 тэрбум төгрөгийн зузаатгал авч 46.4 тэрбум төгрөгийг Монголбанкинд шилжүүлжээ.

Гүйлгээнд гарсан мөнгөн тэмдэгтийн орж ирсэн байдлыг харуулбал./Хувь/



1 ТӨГРӨГ – 143 X 80 MM



3 ТӨГРӨГ – 151X82 MM



5 ТӨГРӨГ – 154X82 MM



1941 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

1940 оны 6 дугаар сарын 30 ны өдөр баталсан БНМАУ-ын хоёр дахь Үндсэн хуулиар үндэсний "Сүлд", "Далбаа" шинэчилсэн билээ. Анх удаа төрийн сүлдэн дээр "Бүгд Найрамдах Монгол Ард Улс" гэж улсынхаа нэрийг бичсэн бөгөөд албан ёсны бичигт крилл үсгийг хэрэглэх болсон

зэрэг өөрчлөлтүүдийн улмаас мөнгөн тэмдэгтийг дахин шинэчлэх асуудал зүй ёсоор тавигдаж эхэлжээ. 1941 оны мөнгөн тэмдэгт 1,3,5,10,25,50,100-н төгрөгийн дэвсгэртэй, бүгд адил бичвэртэй, нэрлэсэн үнэ, өнгөөрөө ялгагдана. Серийн дугаар нь хоёр үсэг, зургаан оронтой тоотой байв.

100 ТӨГРӨГ – 184X100 MM



10 ТӨГРӨГ – 166X88 MM



25 ТӨГРӨГ – 168X95 MM



50 ТӨГРӨГ – 181X98 MM





БОЛОВСРОЛ:

2005–2008 он: МУИС-ийг олон улсын эдийн засагч, бакалавр

2013–2015 он: Люксембургийн их сургуулийг банк, санхүүгийн магистр

Мэргэжил дээшлүүлсэн, хуримтлуулсан туршлага:

2009 он: Польшийн Төв банк

2011 он: Германы Төв банк

2012 он: ОУВС

2013 он: Энэтхэгийн Төв банк

АЖЛЫН ТУРШЛАГА:

2008–2016 он: Монголбанкинд Хяналт шалгалтын газарт хянан шалгагч, ахлах хянан шалгагч

2015–2016 он: Люксембургийн “Шродерс” хөрөнгө оруулалтын санд ажилтан

2016–2018 он: Монгол Улсын Хөгжлийн банкинд Дэд захирал бөгөөд Эрсдлийн үнэлгээ, удирдлагын газрын захирал

2018 он: Төрийн банкны гүйцэтгэх захирал

Төрийн банкны гүйцэтгэх захирал
Г.Дөлгөөнтэй ярилцлаа.

Г.ДӨЛГӨӨН: ТӨРИЙН БАНКНЫ АШИГТ АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ, НЭР ХҮНДИЙГ ӨСГӨХӨД АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА

ТА ТӨРИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН АЖЛАА АВААД УДААГҮЙ БАЙНА. АЖЛАА ЮУНААС ЭХЛЭВ? ЦААШДЫН ТОМ ЗОРИЛГОО ХЭРХЭН ХАРЖ БАЙНА ВЭ?

Миний хувьд Төрийн банк гэдэг их айлд ирээд ажлаа аваад удаагүй байна. Төрийн банк бол Монгол Улсын өнцөг булан бүрт 500 гаруй салбар нэгж, 3800 ажилтантай, 2.9 сая харилцагчидтай, системийнхээ хэмжээнд эхний 3-т орох том банк юм. Ажлаа аваад хамгийн түрүүнд ТУЗ-ийн шийдвэрийн дагуу бүтцийн өөрчлөлт хийн мэргэшсэн, цомхон удирдлагын багаар бүтцээ шинэчлсэн. Тухайлбал удирдлагын багийн 70 захирлыг 40 болгож цөөлөөд байгаа юм. Гэхдээ энэхүү бүтцийн өөрчлөлтийн явцад нэг ч ажилтанг ажлаас нь чөлөөлөөгүй гэдгийг хэлэх нь зөв байх. Миний хувьд цаашид компанийн зөв соёлыг бий болгоход анхаарах замаар банкны үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээг

хөгжүүлэх, өмнөх онуудад хийсэн ажлаа ахиулах, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх, банкны нэр хүндийг өсгөхөд чиглэн ажиллаж байна.

2015, 2016 ОНУУДАД БИЙ БОЛСОН ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛ СҮҮЛИЙН ХОЁР ЖИЛД ААЖМААР ИЛААРШИЖ БАЙНА. ГЭХДЭЭ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН НӨЛӨӨ БАНКНЫ САЛБАРТ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТӨӨР ХАРАГДАХ БОЛСОН. ТЭГЭХЭЭР ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ ХЭР БАЙНА ВЭ, МУУ ЗЭЭЛҮҮДЭЭ ХЭРХЭН МЕНЕЖМЕНТ ХИЙДЭГ ВЭ?

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, зах зээлийн нөхцөл байдлын хувьд таагүй байсан нь банкны секторын чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн. Манай банкны хувьд чанаргүй зээлийн хувь хэмжээгээр секторын хамгийн бага үзүүлэлттэй байгаа. Банкны хувьд зээлдэгч авсан зээлээ хугацаандаа эргэн төлөх боломжгүй тохиолдол гардаг ч харилцагчийн төлбөрийн чадвар, нөхцөл байдлыг судлаад зээлийн хугацааг сунгах, эргэн төлөлтийн хуваарийг өөрчлөх,

дахин санхүүжилт хийх, эрсдэл өндөртэй бизнесийн салбарт санхүүжилт олгохгүй байх зэрэг олон талаар ажилладаг. Цаашид чанаргүй зээлийг төлүүлэх, зээлийн эрсдэлийн бууруулах чиглэлээр хэд хэдэн ажлууд хийхээр төлөвлөгөө гаргаад ажиллаж байна.

ЕР НЬ БАНКУУД ӨӨРСДӨӨ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛЭЭ ЯАГААД ШИЙДВЭРЛЭЖ ЧАДАХГҮЙ БАЙНА ВЭ. ҮҮНТЭЙ ХОЛБОГДУУЛААД АСУУХАД ТӨР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ ӨӨР ДЭЭРЭЭ АВАХ АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИ БАЙГУУЛАХ АСУУДАЛ ЯРИГДАЖ БАЙГАА ШҮҮ ДЭЭ?

Монголбанкны мэдээллийн дагуу улсын хэмжээнд 2018 оны 2 дугаар сарын байдлаар арилжааны банкууд нийт 13.8 их наяд гаруй төгрөгийн зээлийг аж ахуйн нэгж, иргэдэд олгоод байгаагаас 1.26 их наяд төгрөгийн зээл нь чанаргүй гэсэн ангилалд ороод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.3%-иар, оны



эхнээс 9.8%-иар өссөн үзүүлэлт юм байна. Олон улсын жишгээр чанаргүй зээлийг удирдах нэг арга бол Активын удирдлагын компани байгуулах юм байна. Өнөөдрийн байдлаар Монголбанкнаас Активын удирдлагын компанийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд ингэснээр банкны системд үүсээд байгаа чанаргүй зээлийг шийдвэрлэхэд чухал нөлөөтэй институц бий болох юм. Олон улсын туршлагаар Активын удирдлагын компани нь өөрийн гэсэн тусдаа хуультай байдаг бөгөөд банкны тухай хуульд нь холбогдох тусгай заалтуудыг тусгаж өгсөн байдаг. Активын удирдлагын банкны нэг үүрэг нь хүндрэлд орсон банк, санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийг худалдаж авах, удирдах явдал юм. Товчхондоо зээл чөлөөлөх үүрэг хүлээнэ гэсэн үг. Мөн тэрээр хувь эзэмших эрх, үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, авто машин болон бусад активыг худалдан авах боломжтой. Түүнчлэн олон улсын жишгээр чанаргүй зээлийг

удирдах 2 дахь арга нь зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс зээл нь чанаргүй, улмаар муу ангилалд шилжих нөхцөл байдал үүсч байгаа тохиолдолд гэрээний үүргийг биелүүлэн холбогдох арга хэмжээг шуурхай, зардал багатай шийдвэрлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх байдаг. Өнөөдрийн манай улсад энэ нь шаардлагатай байна.

ТӨР ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ КОМПАНИ БАЙГУУЛСАН ТОХИОЛДОЛД ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН НУРУУН ДЭЭР ИРЭХ АЧААЛАЛ ХЭР ИХ БАЙХ БОЛ, ЕР НЬ ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ПРОЦЕСС ХЭРХЭН ЯВАГДДАГ ЮМ БОЛ?

Чанаргүй зээлийн хэмжээ өндөр байх нь тухайн банкны зээл олголтыг хязгаарлахаас гадна тухайн улсын хэмжээнд авч үзвэл эдийн засгийн хөгжилд нөлөөлдөг талтай. Чанаргүй зээлийн түвшин тодорхой хугацааны туршид нэмэгдэж буй тохиолдолд төрөөс чанаргүй зээлийг удирдах зөв арга замыг олсноор эдийн засаг эргэж сэргэхэд түлхэц өгдөг байна. Олон улсын жишгээр харахад Өмнөд Солонгос улс нь

Хөрөнгийн удирдлагын “КАМСО” хэмээх компанитай. Европын төв банкнаас чанаргүй зээлийг удирдах нэгдсэн чиглэлийг баримт бичгээр гаргасан бөгөөд тус баримт бичигт Европын банкуудад чанаргүй зээлийн удирдлагын хүрээнд заавал гүйцэтгэх үүрэг болгон оруулаагүй боловч хэрэгжүүлээгүй тохиолдолд Европын банкнаас арга хэмжээ хүртэл авахаар тусгагдсан байна. Түүнчлэн Европын холбооноос Хөрөнгийн удирдлагын компанийг бий болгох хөгжүүлэх саналыг хэлэлцэж байгаа. Манай банк нь чанаргүй зээлийг шүүхийн болон шүүхийн бус журмаар төлүүлдэг. Шүүхийн бус журмаар төлүүлнэ гэдэг нь тухайн зээлдэгчтэй харилцан тохиролцож зээлээ төлөх боломжит хугацаа олгож, зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулж зээлийг төлүүлдэг. Зээлдэгчтэй харилцан тохиролцоогүй буюу барьцаа хөрөнгийн чанар байдал муудах эрсдэл үүсэх тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны дагуу тухайн барьцаа хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулж барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулдаг.

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ ЧУХЛААР ТАВИГДАХ БОЛСОН. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДЛЫГ ТА ХЭРХЭН ХАРЖ БАЙНА ВЭ?

Олон улсын түвшинд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал чухлаар тавигдах болсон шалтгаан нь санхүүгийн салбарын хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон авч үзэж буйд оршиж байгаа гэж хувийн зүгээс харж байгаа. Монгол Улс ч бас 2018 онд Төв банкны тухай

хуулиндаа өөрчлөлт оруулж, тус банкны үндсэн үүргүүдэд санхүүгийн салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах зүйл заалтыг тусгаснаар дэлхийн жишгээр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн зохицуулалттай болоод байна. Ингэснээр Монголбанкны зүгээс иргэний эрхийг хамгаалсан үйл ажиллагаа явуулах боломжтой болсон буюу арилжааны банк болон иргэд хоорондын маргааныг аль болох шүүхийн шатнаас өмнө буюу төв банкны хяналт, шалгалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой болох юм байна. Үүний тулд Монголбанканд банкны зохистой харьцааг хангуулах хяналт, шалгалтаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт, шалгалтын нэгж ажиллахаар болсон байна. Мөн “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль”-ийг боловсруулж, УИХ-аар батлуулахыг зорьж буйг миний хувьд дэмжиж байгаа. Банкуудын хувьд харилцагчийн санхүүгийн мэдлэг, сахилга бат нэмэгдсэнээр иргэд маань орлого, зарлагаа зөв тодорхойлж чаддаг болохоос гадна зээлийн төлбөрийн зөрчил буурах, харилцагчдын зээлийн түүх сайжрах зэрэг олон давуу талууд бий болно гэж харж байгаа.

ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ЯМАР АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ТАЛААР ЯРИНА УУ?

Монголбанк санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авч буй иргэн, аж ахуйн нэгж болон ирээдүйн санхүүгийн хэрэглэгчид руу чиглэсэн суурь мэдлэг олгох, эрх үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах, ингэснээр гарч болох эрсдэлээс хамгаалах чадвар суулгах зорилгоор “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяныг

2018.01.01-2018.05.30 хооронд зохион байгуулж байгаа бөгөөд уг аяны хүрээнд Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Төрийн банкны Улаанбаатарын 75 нэгж, орон нутгийн 421 нэгжид “Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах” өдөрлөгийг зохион байгуулж, харилцагчдад ирсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг талаар мэдээлэл өгч ажилласан.

ТӨРИЙН БАНК ХУВЬЧЛАГДАХ ТУХАЙ БАЙНГА ЯРИГДДАГ. ХУВЬЧЛАГДАХАД ХЭР БЭЛТГЭЛ АЖИЛ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ТА ҮЗДЭГ ВЭ. ЕР НЬ АНХ БАЙГУУЛАГДСАНААСАА ХОЙШ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ, МЕНЕЖМЕНТИЙН ХУВЬД ХЭР САЙЖИРСАН ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Төрийн банк 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хуучин Зоос банкны суурин дээр 100 хувь төрийн өмчит арилжааны банк болон байгуулагдсан. Үүнээс хойш 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Хадгаламж банкийг мөн нэгтгэж авсан байдаг. Хадгаламж банкны сайн активуудыг шилжүүлэн авч, муу активууд нь Хадгаламж банкны эрх хүлээн авагчид үлдсэн юм. Тус нэгдлийн дараа Төрийн банкны нийт актив 1,365.8 тэрбум төгрөг болж даруй 967.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэн, системийн хувьд ач холбогдол бүхий банкуудын нэг болсон. Харин 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар манай банкны нийт актив 2,426.8 тэрбум төгрөгт хүрээд байгаа нь Хадгаламжийн банкийг нэгтгэснээс хойш 78 орчим хувийн өсөлттэй байна гэдэг нь чамлахааргүй амжилттай ажиллаж байгаагийн илрэл гэж үзэж байна. Банкны секторын хувьд хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа гадаад орчны нөлөөллийг

дагаад холбогдох бодлого, дүрэм, журамдаа өөрчлөлт оруулж эрсдэлийн удирдлагын болоод бусад хэм хэмжээг тогтмол шинэчлэн дагаж мөрдөж байдаг. Энэ утгаараа Төрийн банкны үйл ажиллагаандаа дагаж мөрддөг олон дүрэм, журмуудыг шинэчлэх, харилцагчдыг чирэгдүүлдэг, урт дараалал үүсдэг зэрэг байдлыг бууруулах тал дээр анхааран ажиллаж байна. Төрийн банкны хувьчлалын хувьд банкны хувьцаа эзэмшигч, Засгийн газрын шийдвэрлэх асуудал тул тодорхой хариу өгөх боломжгүй байна. Гэхдээ банкны менежментийн багийн хувьд хэзээ хувьчлахаас үл хамааран банкны үйл ажиллагааг тогтмол, эрсдэлгүй явуулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

СҮҮЛИЙН ЖИЛ ОРЧМЫН ХУГАЦААНД АНХААРЛЫН ТӨВД ОРСОН БАС НЭГ АСУУДАЛ НЬ ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ. БАНКУУД ДОР БҮРНЭЭ ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХЫГ ЗОРЬЖ АЖИЛЛАДАГ. ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД ЭНЭ ЧИГЛЭЛД ХЭРХЭН АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

Төрийн банк нь Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажилладаг. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, орон сууцжуулах төслүүдээс гадна цалин, тэтгэврийн зээлээр жишээ дурдахад 2017 оны 1 дүгээр сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд Төрийн банк нь 18 тэрбум төгрөгийн тэтгэврийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Мөн оюутны хөгжлийн болон багш, эмч нарт зориулсан цалингийн хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон. Түүнчлэн банкны зүгээс эх үүсвэрийн хүү болон Монголбанкны бодлогын хүүтэй уялдуулан зээлийн хүүг тогтоодог, Монголбанкнаас улс орны хэмжээнд зээл, зээлийн хүүтэй холбоотой зохицуулалтыг

хийдэг эрх бүхий байгууллага гэдэг талаасаа банкуудын хувьд Монголбанкны 2018-2023 оны Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтээс тодорхой үр дүн гарна гэсэн хүлээлттэй байгаа бөгөөд энэ хүрээнд цаашид зээлийн хүүг бууруулах боломж гарна гэж харж байгаа.

ТӨРӨӨС ОЛГОГДОЖ БАЙГАА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ШИНЖТЭЙ БОДЛОГУУД ТАНАЙ БАНКААР ДАМЖИЖ ХЭРЭГЖДЭГ. ЭНЭ УТГААРАА ТАНАЙ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ АЧААЛАЛ ИХТЭЙ БАЙХ НЬ ЭЛБЭГ. ТЭГЭХЭЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ, САЛБАРУДАА НЭМЭГДҮҮЛЭХ, АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ХЭРХЭН АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

Төрийн банк нь төрийн үйлчилгээ болох халамж, тэтгэврийн олголтыг 500 гаруй салбар нэгжээр дамжуулан иргэдэд хүргэж байгаа бөгөөд улсын хэмжээнд олгогдож байгаа нийт халамж тэтгэвэр авагчдын 50 орчим хувьд Төрийн банк үйлчилж байна. Үүнээс үүдээд одоогийн байдлаар сар бүр халамж, тэтгэвэр олгох үеэр буюу сар бүрийн 1-5-ны өдрүүд болон 15-20-ны өдрүүдэд нэгжүүдийн ачаалал эрс ихэсдэг. Ачаалал ихсэх шалтгаан нь халамж хоёр шугамаар санхүүждэгтэй холбоотой. Тодруулбал, нэгдүгээрт, Орон нутгийн төсвийн санхүүжилттай халамж гэж байгаа. Энэ төрлийн халамжийн санхүүжилт нь 100% орж ирдэггүй учир халамж авах иргэдэд 100% олгож чадахгүй тул банкин дээр өөрийн биеэр ирсэн иргэн авах боломжтой болоод байгаа юм. Хэрвээ санхүүжилт нь бүрэн орж ирдэг бол харилцагч нь халамжийн мөнгөө төрийн банкны нэрийн дансанд холбох үйлчилгээг сонгож болох бөгөөд уг үйлчилгээг авсан тохиолдолд харилцагч банкин дээр ирэх шаардлагагүйгээр халамжийн

мөнгөө авах боломжтой. Хоёрдугаарт, улсын төсвийн санхүүжилттэй халамж байгаа. Энэ төрлийн халамжийн санхүүжилт нь 100% орж ирдэг тул халамж авах иргэн бүр тус халамжийн мөнгийг авдаг тул банкны карт болон бусад бүтээгдэхүүнээр дамжуулан авах боломжтой байгаа юм. Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 насны хүүхэд асарсны, ихэр хүүхдийн тэтгэмж, 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж, хүүхдийн мөнгө хамаарагдана. Мөн дээрх гүйлгээнээс гадна иргэд маань орон сууц, хэрэглээний төлбөрөө цалин буух үер төлдөг нь халамж, тэтгэвэртэй давхцаж, гүйлгээний ачааллыг нэмэгдүүлдэг. Банкны зүгээс ачааллыг бууруулахад чиглэсэн ажлуудыг эрчимтэйгээр хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал, манай банкны "Гялс" үйлчилгээ байна. Иргэд энэ үйлчилгээг ашигласнаар орон сууц, хэрэглээний төлбөр болон бусад гүйлгээнүүдээ орон зай харгалзахгүйгээр интернэттэй орчинд банкинд заавал ирэхгүйгээр хийх боломжтой. Нэг зүйлийг нэмж хэлэхэд Төрийн банкны Улаанбаатар хотын 60 нэгжид "Гялс булан" ажиллуулж байна. Энэ нь харилцагч банкин дээр ирж, гүйлгээний ажилтны шаардлагагүйгээр өөрөө гүйлгээгээ хийгээд гарах боломжтой юм. Түүнчлэн ачаалал ихтэй нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод зохион байгуулалт хийж, теллерийн барьерийн тоог нэмэгдүүлэх, банкны салбар, нэгжийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх, халамж, тэтгэврийн мөнгийг картаар дамжуулан олгох зэрэг ажлуудыг хийж байна. Үүнээс гадна орлогын АТМ-ыг хөрөнгө оруулалтын

төлөвлөгөөндөө тусган үе шаттайгаар нэмэгдүүлэн ажиллаж байна.

ТӨГСГӨЛД НЬ АСУУХАД, САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙГООР ИРГЭДИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЯРИГДДАГ. ТАНАЙ БАНКНЫ ХУВЬД ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЕХНОЛОГИЙН ДАВУУ ТАЛ, ШИЙДЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ ТАЛААР ХЭРХЭН АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА ВЭ?

Тиймээ, үнэхээр мэдээллийн аюулгүй байдлын асуудал хурцаар тавигдаж байгаа энэ үед бид, үнэ цэнэтэй, чухал активын нэг болсон мэдээлэл, түүний дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэрэг, халдлагаас сэргийлэхэд онцгой анхааран ажиллаж ирлээ. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа банк санхүүгийн байгууллагууд цахим халдлагад ихээхэн өртөж санхүүгийн хохирол амссаар байна. Иймд, бид хамгаалалтын техник технологио цаг үетэйгээ нийцүүлэн байнга шинэчлэн сайжруулахын тулд судалгаа шинжилгээ тогтмол хийж шат дараалалтай арга хэмжээ авч ажилладаг бөгөөд жил бүр шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийсээр ирлээ. Өнгөрсөн жил гэхэд л, гадаад дотоод сүлжээ, веб программуудын аюулгүй байдлыг сайжруулан дэвшилтэт технологиудыг нэвтрүүлсэн. Харин энэ жил мэдээлэл алдагдах эрсдлийг бууруулах чиглэлээр ажиллаж байна. Нөгөөтэйгүүр техник технологио сайжруулахын зэрэгцээ түүн дээр ажиллах мэдээллийн аюулгүй байдлын ажилтнуудынхаа ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургаж дадлагажуулахад анхаарч ажиллах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарч байгаа, энэ чиглэлээр ч анхааран ажиллаж байна.

ЯРИЛЦСАНД БАЯРЛАЛАА.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ.ДОЛЛАРААР, 26/IV ӨДРИЙН БАЙДЛААР)



ОУВС “ПРОТЕКЦИОНИСТ” ГАДААД ХУДАЛДААНЫ



БОДЛОГООС ТАТГАЛЗАХЫГ УРИАЛЛАА

Жил тутам зохион байгуулагддаг Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банкны хаврын ээлжит чуулга уулзалт 4-р сарын 16-22 өдрүүдэд АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдаж өндөрлөлөө. Уг чуулга уулзалтаар гишүүн улсуудын Төв банкны тэргүүнүүд, Сангийн сайд нар, парламентын гишүүд, эдийн засгийн чиглэлийн эрдэмтэн шинжээч нар, бизнесийн болон хэвлэлийн төлөөлүүд

оролцож, дэлхийн эдийн засгийн хандлага, үүсээд буй сорилт бэрхшээлүүд, ядуурал нийгмийн асуудлууд, эдийн засгийн хөгжил, тусламж санхүүжилтийн үр ашигтай байдал зэрэг сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлгүүд өрнүүлдэг билээ. Энэ удаагийн хаврын чуулга уулзалтад Монгол Улсаас Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан тэргүүтэй төлөөлөгчид оролцсон.

“Монголбанкны мэдээлэл” товхимлын 4-р сарын дугаартаа бид тус чуулга уулзалтаар хэлэлцсэн гол асуудлууд, дэвшүүлсэн саналуудыг багцлан хүргэхээр зориллоо.

Дэлхийн эдийн засгийн төлөв, тулгараад байгаа эрсдэл хүндрэлүүдийг хэлэлцэж ОУВС, Дэлхийн Банкны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр ОУВС, Дэлхийн банкны

хамтарсан Хөгжлийн хороо, ОУВС-ийн Мөнгө, санхүүгийн хорооны 37-р чуулга уулзалт боллоо. ОУВС-ийн болон Дэлхийн банкны чуулга уулзалтуудын үеэр хэлэлцэх асуудал, шийдвэрүүдийг эдийн засагч, шинжээчид, бодлого тодорхойлогч нар анхааралтайгаар ажигладаг бөгөөд энэ удаагийн чуулга уулзалтаар худалдаа, технологи, өрийн асуудал гэсэн үндсэн сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлээ.

ХУДАЛДАА

Дэлхийн эдийн засаг худалдаа, хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр өсч, ойрын хугацааны эрсдэл буураад байна. Одоо үүсээд байгаа боломжийг ашиглаж тогтвортой, хүртээмжтэй, ажлын байраар тэтгэгдсэн дунд хугацааны өсөлтийг бүрдүүлж чадах бодлогын реформуудыг хийх нь юун түрүүний ажил болохыг энэхүү чуулганаар хэд хэдэн удаа тэмдэглэсэн. Ялангуяа энд мөнгө, төсөв, бүтцийн бодлогын реформууд, тэдгээрийн уялдаа хамаарлыг онцолсон юм.

Хэдийгээр улс орнуудын хамтын ажиллагааг дэмжиж байгаа ч сүүлийн үед дэлхийн эдийн засагт томоохон цочроо өгч, эргэлзээтэй байдлыг үүсгээд байгаа АНУ-ын “протекционист” гадаад худалдааны бодлого чуулганы халуун сэдэв болсон. Ерөнхийлөгч Трампын шийдвэрээр жимс жимсгэнээс авахуулаад уул уурхай, аж үйлдвэрийн гол түүхий эд болох ган, хөнгөн цагаан зэрэг 128 нэр төрлийн бүтээгдэхүүнд АНУ импортын тариф тавьсан нь дэлхийн хоёр дахь эдийн засаг БНХАУ-ын худалдаанд сөрөг шок болоод байна. Нөгөө талаас БНХАУ-аас хариу болгож АНУ-аас импортолдог 106 нэр төрлийн бүтээгдэхүүндээ тариф тавихаа мөн зарласнаар дэлхийн хоёр том гүрний хооронд худалдааны дайн үүсэх аюулыг төрүүлээд байгаа аж.

Уг хурцадмал нөхцөл байдлаас үүдэлтэйгээр ОУВС-ийн тэргүүн Кристин Лагард хурлын үеэр улс орнуудыг “протекционист” гадаад худалдааны бодлогоос татгалзахыг уриалаад, хэрэв энэ чигээр үргэлжилбэл дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлөхийг анхааруулсан. Угаас “протекционист” бодлого нь том дүр зургаар харвал өндөр үр ашиг авчирч чадахгүй ба нийгмийн дундаас доош давхаргыг тамирдуулах уршигтай аж. Тиймээс ч чуулганы үр дүнд АНУ болон БНХАУ-ын нөлөө бүхий албаны хүмүүс хэд хэдэн уулзалтыг хийснээр АНУ-ын Сангийн Сайд Стевен Мнучин ойрын хугацаанд Бээжин хотод айлчлал хийхээр болсноо мэдэгдлээ. Стевен Мнучин хэлэхдээ “энэхүү айлчлал хэрэв болбол би асуудлыг харьцангуй өөдрөгөөр харж байна” гэжээ.

ТЕХНОЛОГИ

Чуулга уулзалтын үеэр хэлэлцүүлэг өрнөсөн өөр нэг чухал сэдэв бол санхүүгийн технологи буюу финтек болон криптовалют байсан. ОУВС-аас криптовалют болон блокчейн технологийг дэлхийн санхүүгийн тогтолцоонд ашиглах талаарх нэгдсэн зохицуулалтыг бий болгохыг эрмэлзэж ажиллаж байгаа аж. Хэдийгээр криптовалютын зах зээлийн үнэлгээ харьцангуй бага ч гэсэн, улс орнуудын санхүүгийн тогтвортой байдал болон хөгжил дэвшилд аюул заналхийлэл учруулж болзошгүй учраас ОУВС энэхүү санаачилгыг өөртөө авч ихээхэн ажлуудыг өрнүүлээд байна.

Криптовалютад тодорхой зохицуулалт хэрэгтэй гэдэг дээр хуралд оролцогчид бүгд санал нэгдсэн бөгөөд тэр дундаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг аливаа санхүүгийн гэмт хэрэгт ашиглахаас сэргийлэх нь юун түрүүнд хийх ёстой ажил аж. ОУВС-ийн Мөнгө, санхүүгийн хороо болон тухайн үед болсон Их 20 уулзалтын үеэр, шинэ тутам технологи, криптовалют нь уламжлалт мөнгөн тэмдэгтийн орыг ойрын хугацаанд авах эрсдэл байхгүй ч төв банкууд цаг үетэйгээ нийлж ажиллах нь зүйтэй гэдгийг харуулсан. Тиймээс ч зарим Төв банк дижитал мөнгө гаргах бэлтгэл ажлаа эхлүүлээд байгаа билээ. Учир нь криптовалютад ашиглагдаж байгаа блокчейн технологи нь зуучлалын үүргийг хөнгөвчилснөөр төлбөр тооцооны хувьд үр ашигт болон аюулгүй байдлыг нэмэгдүүлэх том давуу талтай юм.

Гэхдээ улс орнууд тодорхой зүйлс дээр санал нэгдэж байгаа ч, нөгөө талаар мөн зөрүүтэй байр суурьтай байгаа нь илэрхий байв. Тухайлбал зарим улс крипто зохицуулалт хийхэд laissez-faire буюу чөлөөт зах зээлийн орчныг бүрдүүлэх ёстой гэж байгаа бол зарим нь хэрэглээг нь таслан зогсоох, эсвэл хатуу бодлого баримтлах ёстой гэх зэргээр байр сууриа илэрхийлсэн. Энэ зөрчилдөөнтэй үед зохицуулалтыг хийх хүндхэн даалгавар ОУВС-д очиж байгаа бололтой. Учир нь Төв банкууд хамтарч ажиллаж чадахгүй байгаа үед тэдгээрийг нэгтгэж байгаа институт нь үүнийг өөр дээрээ авах нь илүү боломжтой харагдаж байна.

Технологийн хүрээний хоёр дахь том асуудал бол хиймэл оюун ухаан (AI) буюу түүнийг ашиглаж байгаа томоохон компаниудын талаарх хэлэлцүүлгүүд байлаа. AI нь хүмүүсийн амьдралын чанар, эрх, аюулгүй байдал, хүсэл хэрэгцээ гээд маш өргөн хүрээнд эерэг сөргөөр нөлөөлж байгаа. Тиймээс энэ технологийн хэрэглээг хэрхэн зохицуулах, ямар этик, ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ашиглах гэдэг нь өөрөө чухал сэдэв юм. Мөн Amazon, Facebook, Google зэрэг хэрэглэгчийн асар их хэмжээний мэдээлэлтэй компаниудыг АНУ-ын төрөөс дарамт үзүүлж байгаа талаар ярилцсан ба ОУВС-ийн тэргүүн хэлэхдээ “Зах зээлийн давамгайл байдалтай болсон Амазон зэрэг компаниуд Засгийн газар болон бусад институтуудтай хамтарч ажиллах нь зөв боловч нөгөө талаас төр нь өөрөө Амазоныг нухчин, задалж хуваах нь зөв алхам гэдэгт би эргэлзэж байна” гэжээ.

ӨРИЙН АСУУДАЛ

ОУВС, Дэлхийн банкны хамтарсан Мөнгө, санхүүгийн хорооны 37-р чуулга уулзалтын үеэр зонхилсон өөр нэг сэдэв бол дэлхий нийтийг хамарсан өрийн асуудал байлаа. 2017 оны эцсээр дэлхийн улс орнуудын 80 орчим хувьд эдийн засаг өсөлттэй гарснаар 2008 оны хямралаас хойшхи хамгийн эерэг үзүүлэлттэй жил болсон. Ойрын хоёр жилийн хугацаанд энэхүү өсөлт хадгалагдах дүр зураг ажиглагдаж байгаа ч, дунд урт хугацаанд эрсдэл оршсон хэвээр байгааг зохион байгуулагчдын зүгээс анхааруулсан. Тухайлбал, олон оронд өрийн хэмжээ түүхэн дээд түвшинд хүрсэн нь дахин санхүүжилтийн эрсдэлийг дагуулж байна. Тиймээс олдсон энэхүү ахархан боломжийг ашиглаж улс орнууд эдийн засгийн реформыг хийхгүй бол их хэмжээний өр нь дэлхий нийтийг хамарсан санхүү-эдийн засгийн дараагийн хямралын үндэс болж болох эрсдэлтэй аж.

Чуулга уулзалтаар дэлхийн нийт өрийг 164 их наяд ам.доллар буюу дэлхийн ДНБ-ий 225%-д хүрснийг анхааруулаад олон улсын хамтын ажиллагаа, итгэлцэл дутагдаж байгааг тэмдэглэжээ. Нэг талаас улс орон хоорондын итгэлцэл, нөгөө талаас иргэд олон нийтийн өөрийн төр засагтаа итгэх итгэлцэл сул байгааг энд хэлж байгаа аж. Өрийн удирдлага, дахин санхүүжилт дээр итгэлцэл чухал хөшүүргэ болдог учраас улс орнуудын хамтын ажиллагаа нь нэн тэргүүний асуудал болоод байгаа аж.

Нөгөө талаас дөнгөж сэргэж байгаа дэлхийн эдийн засагт өрийн эрсдэл нь дахин уналтыг үүсгэх магадлалтай байгаа тул болгоомжлох нь дамжиггүй юм. Тиймээс ч 2030 оны тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх аливаа үйл хэргийг ОУВС-аас дэмжихээ мэдэгдэж, цаашид өрийн тогтвортой санхүүжилт, ил тод байдлыг нэмэгдүүлж ажиллахаа амласан. Ингэхдээ гишүүн орнуудын төсвийн тогтолцоог бэхжүүлэх, өрийн удирдлагын чадавхыг сайжруулах, зээлдэгч болон зээлдүүлэгч нартай хамтран ажиллаж тогтвортой зээлийн арга туршлагыг төлөвшүүлэх, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах зэрэг чиглэлээр ажиллах аж.

Ийнхүү Дэлхийн банкны хамтарсан Хөгжлийн хороо, ОУВС-ийн Мөнгө, санхүүгийн хорооны 37-р чуулга уулзалт болон бусад бүлэг уулзалтууд 6 хоногийн турш үргэлжилж өндөрлөсөн. Эцэст нь ОУВС-ийн тэргүүн Кристин Лагардын хэлсэн “Нар гийж байгаа энэ үед л амжиж дээврээ зас. Тэнгэрийн хаяанд борооны үүл бөөгнөрч байна” гэсэн үгийг эцэст нь тэмдэглэх нь зүйтэй болов уу.

<https://www.imf.org/en/News/Articles/2018/04/20/pr18140-communique-of-the-thirty-seventh-meeting-of-the-imfc>



МӨНГИЙГ ЗӨВ УДИРДАХ НЬ МӨНГӨӨР ТАСРАХГҮЙ БАЙХ АРГА

Өнөөгийн нийгэмд бидний баян эсвэл ядуу байх, хотын оршин суугч уу эсвэл хөдөөний оршин суугч уу гэдгээс үл хамааран мөнгөөр тасрахгүй байх хамгийн сайн арга бол мөнгөө хэрхэн зөв зарцуулах дадал хэвшлийг өөртөө бий болгох юм. Энэ нь хэрхэн мөнгө олох, хэрхэн түүнийгээ зөв зарцуулж санхүүгийн хүндрэлд өртөхгүй байх мэдлэг олж авахаас эхлэх болов уу.

Олсон мөнгөө яаж зарцуулах, хадгалах уу, зээлэх үү, хөрөнгө оруулах уу гэдгээ сонгох чөлөөт сонголт бидний өмнө байна. Эдгээр сонголтуудыг хийхийн өмнө харин сонголтондоо мэдлэгтэй хандсанаар ирээдүйд ашигтай, үр өгөөжтэй, санхүүгийн дарамтгүй амьдрах нөхцөлөө бүрдүүлж чадна.

Ингэж хэлснээрээ хүн болгон санхүүгийн мэргэжилтэн шиг мэдлэгтэй бай гэсэн үг мэдээж биш. Иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол гэдэг бол өөртөө болон гэр бүлдээ зарцуулах мөнгөн хөрөнгөө хэрхэн зөв зүйтэй зарцуулах тухай л ойлголт шүү дээ.

Санхүүгийн Боловсролыг улс орнууд бага балчираас эхлүүлээд өтгөс буурлуудад хүртэл хөгжилтэй, зугаатай аргаар өгч, мөнгөө зөв удирдах итгэл, дадал хэвшил суулгахыг зорьдог.

Тэгвэл мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?

Бид мөнгөтэй байх дуртай. Харин хөдөлмөрлөж олсон мөнгөө үнэхээр хэрэгтэй зүйлдээ зарцуулж, хэрэглээндээ зөв хуваарилж чадах нь чухал. Мөн зээлээр бараа бүтээгдэхүүн авах эсэхдээ сайн дүгнэлт хийх хэрэгтэй.

Хамгийн эхний алхам бол төсөв хөтлөх юм. Төсөв гэдэг нь таны орлого (цалин), зарлага, хуримтлал.

Ямар нэгэн зүйл зээлээр худалдаж авахаасаа өмнө та доорх асуултуудыг өөрөөсөө асуугаарай.

Авах гэж буй зүйл тань танд үнэхээр хэрэгтэй юу?

Хэрэв зайлшгүй хэрэгцээтэй зүйл авах гэж байгаа бол зээл авахгүйгээр авах өөр арга байна уу?

Авах гэж буй бүтээгдэхүүнээ зээлээр авахаас өөр арга үлдээгүй бол хаанаас хүү багатай зээл авч болох вэ?

Зээл авснаар зээл болон зээлийн хүүг хугацаанд нь эргүүлэн төлж чадах уу?

Дээрх асуултуудын аль нэгэнд нь “үгүй” гэсэн хариулт байвал та зээл битгий аваарай. Хэрэв авсан зээлнээсээ дарамтыг мэдэрч байгаа бол тоохгүй өнгөрч болохгүй. Санхүүгийн хүндрэл, дарамтыг тоохгүй байх нь асуудлыг улам л дордуулна уу гэхээс дээрдүүлэхгүй гэдгийг санаарай. Өр зээлийн асуудлыг шийдэхийн тулд эхлээд хэдий хэмжээний зээлтэй байгаа гэдгээ мэдэж байх нь хамгийн чухал. Зээлсэн мөнгөний тодорхой хэсгийг төлж чадахааргүй байвал зээлдүүлэгчтэйгээ уулзан учрыг тайлбарлаарай.

Гэнэтийн осол, ажлаас халагдах гэх мэт эрсдэл гарсан тохиолдолд хэрэглэх хуримтлалыг заавал үүсгэх хэрэгтэй. Энэхүү хуримтлал нь дор хаяж 3 сарын нөөцтэй байхаар тооцоолон хуримтлуулаарай. Яг одооноос хуримтлуулах боломжгүй бол санаа зовох зүйлгүй ба зорилгодоо хүрэх төлөвлөгөөгөө боловсруулаарай. Тус хуримтлалаа зөвхөн гэнэтийн осол, үйл явдалд л хэрэглээрэй.

Гэнэтийн осол, үйл явдалд хангалттай мөнгө хуримтлуулсан тохиолдолд дараагийн зориулалтууд болох хүүхдийн сургалтын төлбөр, төрсөн өдрүүдийн бэлэг авахад, тавилга авахад гэх мэт зүйлсд зориулсан хуримтлалыг мөн үүсгэж болох юм.

Хэдий чинээ эртнээс мөнгөө удирдаж эхэлнэ төдий чинээ зөв зүйлд мөнгөө зарцуулж, ирээдүйдээ зориулан хуримтлуулж эхлэх болно.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



MBA
MONGOLIAN BANKERS ASSOCIATION



ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ
Deposit Insurance Corporation of Mongolia



MUK
MONGOLIAN MORTGAGE CORPORATION
МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АЯН

2018 01.02-05.31